



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-7</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>8-41</i>

1. “Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолд хэсэгчлэн тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг /үргэлжилнэ/	10-11
2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 07 дугаар дүгнэлт /үргэлжилнэ/	11-13
3. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг, үргэлжилнэ/	13-15
4. Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	15-41

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
9 дүгээр сарын 24-ний өдөр /Лхагва гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 70 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 02 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Батцэцэг, Ж.Баясгалан, Б.Бейсен, Д.Бум-Очир, П.Мөнхтулга, Б.Найдалаа, О.Саранчулуун, С.Цэнгүүн, Ж.Чинбүрэн, М.Энхцэцэг;

Чөлөөтэй: Б.Баярбаатар, Т.Мөнхсайхан;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Х.Болормаа, Ж.Ганбаатар, Б.Жавхлан;

Тасалсан: Б.Дэлгэрсайхан, Б.Энхбаяр;

Хоцорсон: С.Амарсайхан-15 минут, О.Амгаланбаатар-05 минут, Т.Аубакир-08 минут, М.Бадамсүрэн-1 цаг 59 минут, Э.Бат-Амгалан-05 минут, Б.Батбаатар-10 минут, Д.Батлут-05 минут, Ж.Батсуурь-04 минут, Э.Батшугар-07 минут, Ж.Бат-Эрдэнэ-01 минут, Г.Ганбаатар-24 минут, С.Ганбаатар-27 минут, П.Ганзориг-09 минут, Л.Гантөмөр-1 цаг 18 минут, Ц.Даваасүрэн-39 минут, Г.Дамдинням-05 минут, Т.Доржханд-16 минут, Б.Жаргалан-07 минут, Д.Жаргалсайхан-08 минут, Ж.Золжаргал-02 минут, С.Лүндэг-10 минут, Л.Мөнхбаатар-05 минут, З.Мэндсайхан-27 минут, Н.Наранбаатар-03 минут, П.Наранбаяр-05 минут, Н.Номтойбаяр-02 минут, Б.Пунсалмаа-02 минут, Б.Түвшин-25 минут, Ч.Ундрэм-07 минут, Н.Учрал-05 минут, Г.Уянгахишиг-16 минут, Д.Цогтбаатар-03 минут, Б.Чойжилсүрэн-04 минут, Ж.Энхбаяр-10 минут, С.Эрдэнэбат-01 минут, Р.Эрдэнэбүрэн-1 цаг 21 минут.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Ж.Бат-Эрдэнэ үг хэлэв.

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж үг хэлэв.

Нэг. ““Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолд хэсэгчлэн тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг /үргэлжилнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан нар байлцав.

““Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолд хэсэгчлэн тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийн тухай асуудлын санал хураалтаар үргэлжлэв.

Х.Булгантуяа: 1.Төсвийн байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолын 1 дэх заалтын 5 дахь дэд заалтад хэсэгчлэн

тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 30
Бүгд: 94
68.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар, С.Замира, С.Лүндэг, Б.Пүрэвдорж, Г.Хосбаяр, Да.Цогтбаатар, Л.Энхнасан нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 75.5 хувийн саналаар дэмжсэнд тооцов.

2.Төсвийн байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолын 3 дахь заалтад хэсэгчлэн тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авах боломжгүй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 25
Бүгд: 98
74.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа, Да.Цогтбаатар нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 76.5 хувийн саналаар дэмжсэнд тооцов.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан саналыг дэмжсэн тул “Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийн тухай” Улсын Их Хурлын тогтоолыг баталсанд тооцов.

Уг асуудлыг 10 цаг 19 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 07 дугаар дүгнэлт /үргэлжилнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 07 дугаар дүгнэлтийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан саналын санал хураалтаар үргэлжлэв.

Х.Булгантуяа: 1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт “эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад прокурор оролцогчийн гаргасан саналыг харгалзан шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн шүүгдэгчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн арванзургадугаар зүйлийн 13 дахь заалтад “халдашгүй чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл

журмаас гадуур дур мэдэн хэнийг ч ... баривчлах, хорих, ... эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. ... Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. ... ” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 76
Татгалзсан: 23
Бүгд: 99
76.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт “эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад прокурор оролцогчийн гаргасан саналыг харгалзан шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн шүүгдэгчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.” гэж заасан нь Үндсэн хуулийн арванзургадугаар зүйлийн 14 дэх заалтад “шударга шүүхээр шүүлгэх ... эрхтэй ...” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 85
Татгалзсан: 14
Бүгд: 99
85.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт “эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад прокурор оролцогчийн гаргасан саналыг харгалзан шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн шүүгдэгчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 84
Татгалзсан: 15
Бүгд: 99
84.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 07 дугаар дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолыг баталсанд тооцов.

Уг асуудлыг 10 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг, үргэлжилнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Л.Мөнхбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд Д.Батлут, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундрэм, Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Х.Тэмүүжин Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлгээс Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс авсан завсарлага дууссаныг мэдэгдэв./10:26/

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан 10 цаг 29 минутаас хуралдааныг даргалав.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороо болон бусад Байнгын хороодод шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, мөн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Мөнхнасан, Парламентын

судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн ахлах референт Э.Цолмонжаргал, Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын мэргэжилтэн Б.Алтанцэцэг, “Монголын хөдөөг хөгжүүлэх фермерүүдийн холбоо” ТББ-ын тэргүүн Г.Даваадорж, “Монголын тариаланчдын үндэсний холбоо” ТББ-ын тэргүүн Б.Одонхүү, “Биотериал” ХХК-ийн эрдэмтэн, нарийн бичгийн дарга Г.Сувдаа, Хөдөө аж ахуйн их сургуулийн Мал аж ахуй, биотехнологийн сургуулийн захирал Д.Гүрбазар, мөн сургуулийн Агроэкологийн сургуулийн багш З.Эрдэнэчимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, Ж.Түвшинжаргал, референт Б.Энхгэрэл нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, Д.Рэгдэл, Ц.Туваан, М.Ганхүлэг, Д.Ганмаа, Н.Алтаншагай, Н.Наранбаатар, Б.Түвшин нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Мөнхнасан, Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн ахлах референт Э.Цолмонжаргал, “Биотериал” ХХК-ийн эрдэмтэн, нарийн бичгийн дарга Г.Сувдаа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа 11 цаг 30 минутаас хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, М.Ганхүлэг, Х.Булгантуяа нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./12:07/

Уг асуудлыг 12 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа хэлэлцэх асуудлын дарааллын 5-д байгаа “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Улсын Их Хурал дахь намын бүлгүүдээс дахин санал авах шаардлагатай тул хэлэлцэхийг хойшлуулав./12:09/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Чуулганы хуралдааны хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 2 цаг 07 минут үргэлжилж, 126 гишүүнээс 108 гишүүн хүрэлцэн ирж, 85.7 хувийн ирцтэйгээр 12 цаг 09 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН

БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ

ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр, Лхагва гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 02 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы 2025 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн нэгдсэн хуралдаан эхлэхэд бэлэн болсон байна. Улсын Их Хурлын гишүүдийн ирц 55,6 хувьтай. Ингээд өнөөдрийн чуулганы хуралдаан нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн хуралдаанаар дараах 5 асуудлыг хэлэлцэхээр байгаа.

1 дүгээрт ““Алт 3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолд хэсэгчлэн тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

2-т Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 7 дугаар дүгнэлтийг бас үргэлжлүүлэн хэлэлцэж, санал хураалт явагдахаар байгаа.

3-д Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн хийнэ.

4-д Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

5-д “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” асуудлыг хэлэлцэнэ.

Эхний асуудалд оръё.

Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Бат-Эрдэнэ даргын микрофоныг өгье.

Ж.Бат-Эрдэнэ: Өчигдөр Халзан бүрэгтэйн орд газрыг хэрхэн ашиглах вэ гэсэн асуудлаар нийтийн сонсгол явагдсан. Уг нь эдийн засгийн хүрээнд ямаршуу байдлаар ашиглах юм, яаж Монгол Улсынхаа эдийн засгийг өргөжүүлэхийг тэлэх юм гэдэг ийм л ач холбогдол бүхий хэлэлцүүлэг манай гишүүд ч нэлээн ач холбогдол өгч байсан. Баярбаатар гишүүн ажлын хэсгийг ахалсан. Нэлээн ач холбогдол өгч, уг нь бас орон нутгаар нь ч явж үзэж харж явсан ийм юм байгаа юм.

Гэтэл өчигдрийн хэлэлцүүлэг маань ер нь юу болоод өнгөрөв. Хэдүүлээ бас дүгнэлт хийгээд харчихмаар санагдаад байна. Яг өнөөдөр хэвлэл мэдээлэл дээр юу явж байна гэхээр тэр ордын ашиглах асуудал, ач холбогдол асуудал ерөөсөө яригдахгүй байна шүү дээ. Хэвлэл мэдээллээр. Нэг нэгнийгээ айлган сүрдүүлсэн, нэг нэгнийгээ дарамталсан, нэг нэгнийхээ эдийн засгийг боомилсон ийм л зүйлүүд яригдлаа шүү дээ.

Үгүй ээ, энэ бүхнийг хэлэхэд амаар гарахааргүй хэмжээний тийм айлган сүрдүүлсэн, бохир заваан, балиар юмнууд л явлаа шүү дээ энэ хэвлэл мэдээллээр. Тэгэхээр энэ хэвлэл мэдээллийн цензур гэж ер нь юм байна уу, үгүй юу. Хэдүүлээ энэ асуудлаа бас бодвол яасан юм ер нь. Тэгээд тэр ажлаа хийж явж байгаа зарим нэгэн хүмүүсийг нэр дурдаж юу гэнэ үү, тэр нүдийг нь ухаж, тугалга цутгана ч гэх шиг. Амнаас гарахааргүй хэмжээний ийм зүйлүүд. Өнөөдөр эрүүгийн нөхцөл байдал ямаршуу болчихоод байгаа билээ. Яаж залуужаад байгаа билээ. Энэ дээр бас хэдүүлээ бодлого бодохгүй бол ингээд ийм зүйлүүдээ хэвлэл мэдээллээр цензургүйгээр цацаад байдаг. Тэр битгий хэл зарим ярьсан яриануудыг таслаад, сайхан сайхан гэгээлэг ярьсан юмнуудыг таслаад, тэгээд бусад асуудлыг нь энэ хэвлэл мэдээллийнхэн тавиад л байдаг биз дээ. Яахаараа энэ муу муухай зүйлүүдийг ингээд хамаагүй цацаад байдаг юм. Энэ дээр бас хэвлэл мэдээллийн энэ чинь олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ямар зүйлийг явуулах вэ, ямар цензур байх вэ гэсэн нэг зүйл байх нь зүйтэй байх 1.

2 дугаарт. Ер нь эдийн засагтай холбоотой асуудал дээр энэ орд газруудаа ашиглах асуудал дээр хэдүүлээ бас дорвитой арга хэмжээ авахгүй бол болохоо байжээ. Бүх л асуудлаа ирээдүйдээ тавина гэдэг нэг ийм зүйл л яригддаг болоод байна шүү дээ. Өнөөдрийн залуучуудынхаа орон байрны асуудлуудыг шийдэж чадахгүй байж байж юун тэрний дараагийн ирээдүй болсон, ирээдүйн бидний ирээдүйг авч явах залуучууд өнөөдөр амьдарч байгаа хэдэн залуучуудынхаа орон байрны асуудлыг шийдэж чадахгүй байж байж, дараа дараагийнх нь ирээдүйн асуудлуудыг шийдэхээр ингээд арагшаа юмнуудаа тавиад байна гэж бас болохгүй шүү дээ. Асуудлаа шийддэг бол, ашигладаг тэр орд газруудыг өнөөдөр ашиглаад тэр Ховд аймгийн Мянгад сумыг жинхэнэ жишиг хот болгоё л доо. Жишиг сум болгоё л доо. Тэнд олигтойхон шиг эмнэлэг барья л даа. Олигтойхон шиг сургууль барья. Цэцэрлэг барья.

Өнөөдөр хавдраар өдөрт 10 орчим хүн нас барж байна шүү дээ. Үгүй ээ, энийгээ хэдүүлээ бодох хэрэгтэй шүү дээ. Бүсчилсэн тэр хавдрын эмнэлгүүдээ барих хэрэгтэй шүү дээ. Сургууль соёлынхоо асуудлыг барих хэрэгтэй шүү дээ. Ирээдүйн боловсрол болсон асуудал дээр боловсролынхоо асуудлуудыг гаргая. Тэгэхээр энэ асуудлыг бүлэг, энэ асуудлыг Их Хурал ер нь бас тодорхой хэмжээнд авч явсан нь дээр байх шүү гэж бол бодож байна. Монгол Ардын намын бүлэг ч тэр, Ардчилсан намын бүлэг ч тэр бусад бүлэг, нам, эвслүүд ч гэсэн ер нь жоохон юм бодож ажиллахгүй бол ирээдүйд бид нар юу үлдээх юм бэ. Ирээдүйнхээ өнөөдрийн боловсрол, өнөөдрийн эрүүл мэнд, өнөөдрийн эдийн засаг, өнөөдрийн цалинтай, мөнгөтэй ард иргэд нь байх, хангамжтай байх энэ 21 дүгээр зуунд хүн шиг амьдрах энэ боломж бололцоогоо хангая гэсэн ийм 2 асуудлыг хэлэх нь зүйтэй байх гэж харж байгаа юм. Баярлалаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын Тамгын газраас 1 дүгээрт өглөө эрт ирцийг бүрдүүлсэнгүй гэж зарим гишүүдээс гомдол гаргасан юм байна.

2 дугаарт бүлгийн удирдлага Бат-Эрдэнэ дарга үг хэлэхтэй холбоотойгоор 1 номерын микрофоноос Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга үүн дээр тайлбар хэлээдхээч. Бүлгийн дарга энэ дээр завсарлага авахаар байдаг юм уу үг хэлж болно шүү дээ. Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор. 1 номерын микрофон. Пүрэвдорж дарга аа, та дэгээ жоохон бариач. 1 номерын микрофоныг өгье.

Б.Баасандорж: Улсын Их Хурлын дэд дарга, гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе. Сая хуралдаан даргалагч 2 үндсэн асуудлаар тодруулга өгөөч ээ гэсэн.

Сая Ардын намын бүлгийн дарга Бат-Эрдэнэ дарга бол Пүрэвдорж гишүүн ээ би саяын таны асуусан юманд хариулаадахъя. Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой биш, өчигдөр болсон хяналтын сонсголтой холбоотой л үг хэлсэн.

2-т нь Пүрэвдорж дарга, Пүрэвдорж гишүүн ээ ...

Х.Булгантуяа: Пүрэвдорж гишүүн ээ, та дэгээ бариач ээ.

Б.Баасандорж: Би таны хэлсэн асуултад хариулах гээд байна шүү дээ.

Улсын Их Хурлын дэд дарга Пүрэвдорж дарга өглөө цаг бүртгэлийг яагаад 8.30-д эхлүүлэхгүй байгаа юм бэ гэдэг асуудлыг тавьсан. Тэгээд энэ асуудлаар би гишүүддээ тодруулга хэлэх гэсэн юм. 2020 оны Их Хурлын тухай хууль, 2024 оны Их Хурлын тухай хууль аль аль хууль дээр нь тухайн өдөр чуулган эхлэхээс өмнө гишүүд өглөө 9 цаг 00 минутаас эхлэн ирцэд бүртгүүлнэ гэдэг Пүрэвдорж дэд дарга аа хуультай. Хууль байгаа учраас Тамгын газар энэ хуульд заасны дагуу 9 цагаас нээж байгаа. Та 8 цаг 30 минутад ирсэн ч гэсэн 9-өөс нээж байгаа. Та Пүрэвдорж гишүүн ээ, намайг доромжилж болно. Та Тамгын газрын хуулийн дагуу хууль мөрдүүлээд ажлаа хийж байгаа хүмүүсийг танаар би доромжлуулахгүй шүү Пүрэвдорж дарга аа. Төрийн албан хаагчдыг та ингэж доромжилж болохгүй шүү дээ. Таны баталсан хууль шүү дээ Пүрэвдорж даргаа. Энэ байна шүү дээ цагаан дээр хараар биччихсэн. Та хуулиа өөрчилж болно шүү дээ.

Х.Булгантуяа: Пүрэвдорж гишүүн ээ, та Улсын Их Хурлын дэд дарга хүн. Парламентад 3 удаа сууж байна. Хууль дээр 9 цагаас гэж байгаа бол цагаараа л байдаг юм. Тэгэхээр та өөрөө хуулиа уншаад, хуулийн дагуу Улсын Их Хурал үйл ажиллагаагаа явуулъя. Аль нэг улс төрийн өнгө аясыг дагаад Улсын Их Хурлын Пүрэвдорж гишүүнээ, дэд дарга хүн өнөөдөр Улсын Их Хурлын Тамгын газрын төрийн захиргааны хэдэн албан хаагчид руу битгий ингэ.

Ингээд үргэлжлүүлээд асуудлаа хэлэлцээд явъя.

““Алт 3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолд хэсэгчлэн тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг үргэлжлүүлэн хэлэлцье.

Өчигдөр Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж, хариулт авч дууссан байгаа. Одоо Төсвийн байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

1.Монгол Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолын 1 дэх заалтын 5 дахь дэд заалтад хэсэгчлэн тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авах нь зүйтэй гэсэн Төсвийн байнгын хорооны саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт. Гишүүдийн 68,1 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Батын Батбаатар, Улсын Их Хурлын дэд дарга Пүрэвдорж нар дэмжсэнээр, Улсын Их Хурлын гишүүн Хосбаяр.

2.Монгол Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолын 3 дахь заалтад хэсэгчлэн тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авах боломжгүй гэсэн Төсвийн байнгын хорооны саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 90.6-д “Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн 2/3 буюу 66,6 хувь нь Монгол Улсын Ерөнхийлөгч хоригийг хүлээн аваагүй бол хууль, тогтоол хүчин төгөлдөр үйлчилнэ.” гэж байгаа. Энэ 2 дахь хэсэг нь Монгол Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолын 3 дахь заалтад хэсэгчлэн тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авах боломжгүй гэсэн Төсвийн байнгын хорооны саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүйг дэмжье гэдэг саналын томьёоллоор байх ёстой. Ганхуяг гишүүн нэмж тайлбар байхгүй.

Улсын Их Хурлын гишүүдэд томьёоллыг дахин уншиж өгье.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолын 3 дахь заалтад хэсэгчлэн тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авах боломжгүй гэсэн Төсвийн байнгын хорооны саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Лүндэг гишүүн түрүүн дэмжсэнээр дарсан. Төхөөрөмж нь ороогүй байна. Түрүүчийнх дээр тэрийг нь протоколд дэмжсэнээр тооцож авч өгөөрэй гэж байна. Эхний санал хураалт дээр Замира гишүүнийх бас төхөөрөмж ажиллаагүй тул дэмжсэн. Энхнасан гишүүн бас дэмжсэн санал хураалтад бүртгэж өгнө үү гэсэн байна.

Улсын Их Хурлын гишүүд ээ, Пүрэвдорж гишүүн ээ, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга бол энэ дээр өчигдөр тайлбар хийсэн. Улсын Их Хурлын гишүүд ээ санал хураалт. Улсын Их Хурлын гишүүдийн 74,5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ. Нийт 73 гишүүн дэмжсэн байна. Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар. Цогтбаатар гишүүний төхөөрөмж ажиллахгүй байгаа юм шиг байх юм. Тамгын газар очоод үзээдхээрэй. Мөнхтуяа гишүүн дэмжсэнээр. Ингээд нийтдээ 75 гишүүн дэмжсэн байна.

10.19 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 7 дугаар дүгнэлтийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан өчигдөр асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан байгаа. Санал хураалтыг

нэгдсэн байдлаар өнөөдөр хийхээр өчигдөр Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу хойшлуулсан байсан.

Ингээд гишүүд санал хураалтад бэлтгэе.

1 дүгээр асуудал дээр сая тоог нь Тамгын газар нэгтгэж гаргалаа. Нэлээн олон гишүүд араас нь гар өргөсөн тул эхнийх дээр 64, дараачийнх нь 75 гишүүн дэмжсэн байгаа. Ингээд “Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталсанд тооцож байна.

2 дахь асуудал. Дараагийн асуудалд оръё. Санал хураалт.

1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт “эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад прокурор оролцогчийн гаргасан саналыг харгалзан шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн шүүгдэгчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн арванзургадугаар зүйлийн 13 дахь заалтад “халдашгүй чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч ... баривчлах, хорих, ... эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. ... Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. ... ” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт. Гишүүдийн 76,8 дэмжиж, санал дэмжигдлээ.

2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт “эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад прокурор оролцогчийн гаргасан саналыг харгалзан шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн шүүгдэгчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.” гэж заасан нь Үндсэн хуулийн арванзургадугаар зүйлийн 14 дэх заалтад “шударга шүүхээр шүүлгэх ... эрхтэй ...” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт. Гишүүдийн 85,9% нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад прокурор ... Пүрэвдорж гишүүн ээ, энэ Үндсэн хуулийн цэцийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой их чухал юм яриад байх юм. Би бүр уншиж байгаа юмаа сонсохоо байлаа. Ойлгохоо байлаа. Саналын томьёоллыг дахин уншиж танилцуулъя.

3.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт “эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад прокурор оролцогчийн гаргасан саналыг харгалзан шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн шүүгдэгчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт. Гишүүдийн 84,8% нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Хууль зүйн байнгын хорооны санал хурааж дууслаа. Байнгын хорооны саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 7 дугаар дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталсанд тооцлоо.

10.24 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн хийнэ.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн хүсэлтээр завсарлагын хугацааг 2025 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр ажлын 3 өдөр сунгасан байгаа. Завсарлагатай холбогдуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн зүгээс Тэмүүжин дарга үг хэлнэ. Тэмүүжин даргын микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: Дэг зөрчсөн асуудал бол байхгүй. Ер нь бол тодорхой асуудлаар намын бүлэг завсарлага авсан бол яг тэр асуудлыг хэлэлцэхийнхээ өмнө намын бүлгээс заавал энэ завсарлагаа яасан бэ гэдгийг нь сонсож байх ёстой. Тэр өдөр бол сонсголгүйгээр явсан хэлэлцүүлэг. Тэгээд араас бүлэг орж ирээд өмнө авсан завсарлагаа өмнөх үндэслэлээрээ үргэлжлүүлэх хүсэлтэй байна. Гэхдээ яг энэ хугацаанд бас тодорхой асуудал гарсан учраас тэр асуудалтай холбоотой мэдээллийг чуулган дээр бол ярьсан. Тэгснээс биш завсарлага авсан үндэслэл бол өмнө нь авсан завсарлагын үндэслэл хэвээрээ байсан. Одоо бүлэг бол завсарлагаа зогсоолоо гэж хэлж байна.

Х.Булгантуяа: Өмнө нь өгсөн дарааллын дагуу үг хэлэхээр байгаа. Улсын Их Хурлын 5 гишүүн үг хэлээд, үүний дараагаар бүртгүүлсэн 4 гишүүн. Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг.

П.Сайнзориг: Баярлалаа. Одоо 2 хоногийн өмнө хэлэлцэж байсан асуудал дээр би үг хэлж байгаа. Тэгээд яах вэ, зарим сайдуудынхаа хэлж байсныг л өнөөдөр сануулж хэлье дээ. Ялангуяа Уул уурхай, эрдэс баялгийн сайд. Яг энэ төсвийн хууль дээр хариулж байсан шигээ хууль, эрх зүйн орчноо оруулж ирээрэй. Баахан ирээдүй цаг дээр л ярьж байгаа. Хэдүүлээ энийгээ бодит ажил болгочихъё.

Учрал сайд хэлсэн. Гадаадын хөрөнгө оруулалтын хуулийг болон Тендерийн хуулийг оруулж ирж, батлуулж чадахгүй бол дараа жил эдийн засгийн форум энэ тэр хийхгүй гэдгээ хэлсэн. Тэгээд энэ өвөл ер нь Улаанбаатар хөлдөх үү. Эрчим хүчний асуудлыг 3 хуваагаад захирсан. Хэрэг эрхлэх газрын дарга, Доржханд сайд, Чойжилсүрэн сайд. Тэгээд энэ реформууд хаана очиж төгсгөж байгаа юм бэ. Хаана очоод ямар процесстой яваа юм бэ. Баахан гадаад, дотоодоор зугаалсан, зураг авсан л хүмүүс байгаад байгаа юм. Ямар ч бодит үр дүн байхгүй. Тэгэхээр ийм зүйлүүд байх юм. Энийгээ анхааръя. Тэгээд асуудлуудыг бол бүгд мэдээд байна. Зарим нь шийдлээ хэлээд байгаа. Тийм учраас тэр засаг захиргааны нэгжийн өөрчлөлт дээр бол жишээ нь Доржханд сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд 2 оруулаад ирмээр байгаа байхгүй юу. Яриад л байдаг. Мэддэг юм байна лээ шүү дээ

та асуудлыг нь. Ядаж энэ аймгийн төвүүдийн 25 сумыг эхний ээлжид татан буулгачихъя л даа. Ингэж байж урсгал зардлаа хэмнээ л дээ. Энэ хуучин бүтцээр өнөөдрийн бид нарын ярьж байгаа энэ үнэт зүйл, өнөөдрийн ярьж байгаа, бид нарын зорьж байгаа зүйл рүү явж чадахгүй байна.

Эрүүл мэндийн даатгалын сан дээр мөн ялгаа байхгүй. Хүн солиод асуудал шийдэгдэхгүй. Энэ дээр яг бодитой өөрчлөлтүүдийг нь иргэддээ үнэнээ хэлээд хийх хэрэгтэй. Юуг нь үнэ төлбөргүй Эрүүл мэндийн даатгалын сангаас 100% хариуцах юм, юуг нь та төлбөрийг нь тодорхой хэсгийг нь хариуцах юм гэдгийг нь ард түмэндээ хэлмээр байна. Энэ Эрүүл мэндийн даатгалын сангийн чинь бүр бодлого энэ тэр алдагдчихсан юм байна лээ. Архины хордлого тайлах эмчилгээ хийх хүртэл хамруулчихсан юм байна лээ шүү дээ. Тэгээд ерөөсөө архины хамааралтай хүмүүс жилд 6 удаа хүртэл хордлогоо тайлаад, 20 сая төгрөг бичүүлчихсэн байгаа байхгүй юу. Ийм байдлаар чинь энэ төсвийн мөнгө, нийтийн мөнгө ерөөсөө зарцуулалт энэ тэр нь болохгүй байна. Тэгээд маш олон жил ярьсан энэ зүйлүүдээ шийдчихмээр байна. Уул уурхайн бодлогоо тодорхой болгочихмоор байна. Засаг захиргаа нэгжийн өөрчлөлтүүдээ хийчихмээр байна. Энэ гадаадын хөрөнгө оруулалттай банк энэ тэрийг оруулж ирээд, тодорхой дэд бүтцийн төслүүд дээр хөрөнгө оруулалт энэ тэр хийлгэх юм уу, үгүй юу. Мэдэхгүй байна. Тэгээд Наранбаяр сайд батлуулаад өгсөн төсвийг бас анхаармаар байна. Та бас өнөө маргаашийн энэ хэлэлцүүлгүүдийг анзаарсан л байх. Хэдүүлээ бас энэ сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэхээсээ гадна, агуулга руу орохгүй бол ер нь болохоо байчихсан юм байна. Шинжлэх ухаанд итгэдэг энэ иргэдийг бэлтгэх, мэргэжлийн хүмүүсийн хэлж байгаа санал, дүгнэлтийг ядаж сонсож тунгаадаг ийм иргэдийнхээ тэр юм руу орж ажиллахгүй бол наад боловсрол гэдэг чинь гэрчилгээ гардуулах тухай биш юм байна шүү Наранбаяр сайд аа. Тэгэхээр ийм зүйл рүү та бас уг нь их л прогрессив хүн гэж бас таныг үнэлээд яваад байдаг. Тэгэхдээ энэ дээр нэг тийм агуулгын өөрчлөлтүүдийг гаргахад хэдүүлээ ингээд ярьдаг биш, шийдээд энэ Улсын Их Хурал дээр тэгээд нэг тийм гал халуун гэдэг юм уу сайхан мэтгэлцээн өрнөдөг л дээ. Юунаас нь ингээд шийрэгнээд юмаа орж ирэхгүй.

Би Доржханд сайдад би өөдөөс нь харж байгаад хэлье. Би энэ Тендерийн хуулийг чинь танай залуучуудтай болон нийслэлийнхэнтэй болон холбогдох хүмүүстэй суугаад хүлээлгээд өгсөн. Хагас жил, 7 сар болж байна. Өргөн барьчихаж чадахгүй. Бултаад л гүйгээд байдаг. Би өөрөө өргөн барьчихъя гэхээр болохгүй шүү гэдэг үгийг хүнээр дайлгадаг. Тэгээд ийм байдлаар ажил явахгүй. Энэ асуудлуудаа цэгцэлье. Тэгээд өнөөдөр Төсвийн хууль хэлэлцэж байна. Энэ төсвийн хууль чинь хөрөнгө оруулалт талаасаа энэ Тендерийн хуулиасаа болоод хагас жилийн настай болчихлоо. 5 сарын 30-нд тендерээ зарлаж чадахгүй бол бүх хөрөнгө оруулалтуудыг нь хураагаад, Улсын Их Хурлын баталсан хууль чинь бараг үйлчлэл нь зогсчихоод байна шүү дээ Доржханд сайд аа. Тэгэхээр энийг шийдчихмээр байна шүү дээ. Та уг нь шийдье гээд л бараг гал цогтой байдаг. Би уг нь танд итгэл үнэмшил/минут дуусав/

Д.Амарбаясгалан: Энхбаяр сайд үг хэлье. Нэр байна шүү дээ. Нэр өгчихсөн юм байна шүү дээ та. Үг давхардсан байна. Энхбатын Болормаа гишүүн үг хэлье. Ингээд Улсын Их Хурлын гишүүд үг хэлж дууслаа. Байхгүй байна. Үг хэлж дууслаа.

2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын

сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороо болон бусад Байнгын хороонд шилжүүллээ.

Ер нь энэ төсөв хэлэлцэж байгаа үеийг ингээд харахад бас гишүүдээс асууж байгаа асуулт, хэлж байгаа үгийг харахад бол бид хэд хэдэн зүйл дээр бас анхаарч, дараа жилийн төсвийг хэлэлцэхэд төсвийн хуульд бас тодорхой өөрчлөлтүүд хийх шаардлагатай гэдэг нь бас ажиглагдаж байна. Тэгэхээр энэ дээр Улсын Их Хурлын даргын зүгээс улс төрийн намуудтай ярилцаад, ажлын хэсэг байгуулж ажиллах нь зүйтэй юм байна гэж дүгнэж байна. Тухайлбал, Улсын Их Хурал дээр аймаг, сум, багийн хэмжээний хөрөнгө оруулалтын асуудлыг багцалж энд авчирч дан ганц Сангийн яам шийдэж хийж байгаа төсвийн хуваарилалтын зарчим бол их алдагдаж байна гэж үзэж байна. Тэгэхээр орон нутгийн Иргэдийн хурал өөрөө улсын төсвөөс хуваарилагдсан хөрөнгө оруулалтыг нэн шаардлагатай хөрөнгө оруулалтдаа зориулж хуваарилдаг байх тэр эрх боломжийг бүрэн олгож өгөх асуудлыг бид бодитой өөрчлөлт хийх цаг нь болсон байна. Цаашлаад сумын түвшинд, багийн түвшинд шаардлагатай байгаа хөрөнгө оруулалтыг аймаг, сумын иргэдийн хурал дангаараа бие даан шийддэг байх тэр боломжийг нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагад өгөх шаардлага бол нэгэнт бий болжээ гэдэг нь харагдаж байгаа юм.

Ялангуяа 126 гишүүнтэй парламент бүрдлээ. Энэ парламентын онцлог нь өөрөө 60/40-ийн харьцаатайгаар тойргоос бол болон намын жагсаалтаар орж ирж байгаа гишүүд. Үндсэндээ энэ парламент өөрөө улс орны макро түвшний эдийн засгийн бодлогыг гаргаж хэрэгжүүлэх чиглэл дээр нь хяналт тавьж ажиллаж байх үндсэн энэ том үүргээ бол хэрэгжүүлж, аль болох аймаг, сумын орон нутгийн шинж чанартай хөрөнгө оруулалт дээр төвлөрөхгүй ажилладаг болох энэ шаардлага бол нэгэнт үүсжээ гэдгийг харж байгаа. Үүнийгээ дагаад мэдээж орон нутагт тодорхой татварын зохицуулалтыг өөрсдөө хийх эрхийг бас нээж өгөх шаардлага үүссэн юм байна.

Мөн дээрээс нь орон нутгийн түвшинд бизнес эрхлэх тэр боломж дээр илүү хөнгөлөлттэй нөхцөлөөр арилжааны зээлийн зарчмаар бизнес эрхлэх зах зээлийн өрсөлдөөний зарчмаар бизнесээ өргөтгөх тэр боломжуудыг нээж өгөх шаардлага бол нэгэнт үүсжээ гэдэг нь бол харагдаж байна. Тэгэхээр улс төрийн намуудтайгаа ярилцаад, ажлын хэсэг байгуулаад бүгдээрээ бас энэ өөрчлөлтийн төлөө хамтарч ажиллая гэдгийг бас гишүүддээ хэлье.

10.30 цаг.

Дараагийн асуудалд оръё.

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн Мэндбаярын Мандхай танилцуулна. Индэрт урьж байна.

М.Мандхай: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Хөдөө аж ахуйн салбар нь манай улсын эдийн засгийн үндсэн тэргүүлэх салбар бөгөөд хүн амын гол нэрийн хүнсний, үндэсний хөнгөн аж үйлдвэрийн түүхий эдийн зонхилох хэрэгцээг хангаж, хүнс, хөнгөн аж үйлдвэр, худалдаа үйлчилгээний

салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, экспортод шууд болон дам хэлбэрээр онцгой үүрэг гүйцэтгэдэг.

Монгол Улсын нийт ажиллах хүчний 24,5 хувь 2024 оны байдлаар ДНБ-д хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 3,9 хувийг эзэлж байна.

Хөдөө аж ахуйн дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах тогтвортой хөгжлийн суурийг бэхжүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх, нөөцийн ашиглалтыг сайжруулах, төрөөс хөдөө аж ахуйг хөгжүүлэх, дэмжихэд баримтлах бодлогын суурь зарчмыг тодорхой болгох уур амьсгалын өөрчлөлтийг сөрөн тэсвэрлэх тогтвортой хөгжүүлэх хэрэгцээ шаардлагатай байгаа билээ.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолоор баталсан Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 1.1.1-д Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр заасан. Иймд Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судалж, тус салбарт үүсээд буй нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасны дагуу Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлж, түүнд нийцүүлэн анхдагч хуулийн төслийг боловсрууллаа.

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлд тус хууль нь төрөөс хөдөө аж ахуйг хөгжүүлэх бодлогын суурь зарчмыг тодорхойлж, Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн төрөлжилт, өртгийн сүлжээний нэмэгдэл, цогц байдлыг хангах, тогтвортой хөгжлийг дэмжихтэй холбогдсон харилцааг зохицуулахаар тусгалаа. Хуулийн төсөл нь 6 бүлэг, 22 зүйлтэй байна.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эрэлт, нийлүүлэлт, нөөц, ашиглалт, бүтээмжийн дүн шинжилгээ хийх түүнд суурилан тогтвортой хөгжүүлэх, зорилтот хөтөлбөрийг баталж хэрэгжүүлэх, орон нутгийн түвшинд уг зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжилтийг зохион байгуулахаар онцлон заав.

Түүнчлэн, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд төрөөс үзүүлж байгаа дэмжлэгийг оновчтой болгох, чанартай, бүтээмжтэй уялдуулах зорилгоор нийт дэмжлэгийн хэмжээ эдийн засгийн өгөөжийг тооцдог байх харилцааг хуульчлан тусгав.

Хуулийн төсөлд хөдөө аж ахуйн өртгийн сүлжээний үе шат бүрд нэмүү өртөг шингээх боломжийг бүрдүүлэхийн тулд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн ангилал, төрөлжилт, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн өртгийн сүлжээг хөгжүүлэх харилцааг тодорхой болгосон.

Түүнчлэн, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл чанараас хамаарсан үнийн тогтолцоог бүрдүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүний нөөцийн бодлого, судалгаа, хөгжүүлэлтийг төлөвшүүлэх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид хөрөнгө оруулагчдыг дэмжих хэлбэр, чиглэл, шалгуурыг тогтоох, бүртгэл, хяналтын нэгдсэн сүлжээ бий болгох зэрэг дараах зарчмын шинжтэй зохицуулалтын харилцааг тусгав.

Хуулийн төсөлд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн үнэлгээ хийхтэй холбогдсон зохицуулалтыг тусгасан.

Мөн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд холбогдох зохистой дадал, стандарт, техникийн зохицуулалтыг мөрдөх, шаардлагыг хангуулах, чанартай уялдсан үнийн тогтолцоог хөгжүүлэхэд чиглэсэн идэвхжүүлэлтийг төрийн дэмжлэг олгох нөхцөлтэй уялдуулав.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл дэх төрийн удирдлагын тогтолцооны цар хүрээг тогтоож, бүртгэл хяналтын нэгдсэн цахим систем бий болгох харилцааг хуульчлан тусгав.

Хуулийн төслийг дагалдан нэр бүхий 7 хуульд өөрчлөлт оруулахаар боловсруулсан. Хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан хуулийн санаачилгаас дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ.

Хуулийн төслийн үзэл баримтлал Хуулийн төслийг D-parliament цахим сайтад 2025 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр байршуулж, олон нийтээс хуулийн төсөлд санал авсан. Хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг салбарын эрдэмтэн судлаачид, аж ахуйн нэгж, иргэд, мэргэжлийн холбоод, фермер, малчдын төлөөлөл, олон улсын байгууллагын төлөөллийг оролцуулан 2 удаа хэлэлцүүлэг зохион байгуулж, санал, шүүмжийг хэлэлцүүлгийн явцад болон цаасаар хүлээн авсан.

Улсын Их Хурлын даргын 2024 оны 42 дугаар захирамжаар байгуулагдсан Улсын Их Хурлын гишүүдэд хуулийн үзэл баримтлал, хуулийн төслийг танилцуулж, санал, шүүмжийг авав. Дээр дурдсан хэлэлцүүлгүүдийн явцад болон цахимаар цаасаар ирүүлсэн санал шүүмж тус бүрийг дэд ажлын хэсэг дээр хэлэлцэн хуулийн төслөөр зохицуулж байгаа харилцаанд шууд хамааралтай саналыг хуулийн төсөлд тусгаж, зарим зохицуулалтын хэсгийг хасах, нэмэх өөрчлөлт оруулан хуулийн төслийн боловсруулалтыг сайжруулсан.

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл, холбогдох танилцуулга, судалгаа, тайланг Засгийн газарт санал, дүгнэлт авахаар хүргүүлж саналыг авсан болно.

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл батлагдсанаар эдийн засаг, нийгмийн дараах ач холбогдол үр дүн гарна гэж үзэж байна. Улс орны эдийн засгийн үндсэн салбар болох хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийн суурийг бэхжүүлж, төрийн урт дунд хугацааны бодлогын хэрэгжилтийг дэмжиж, дэд салбар хоорондын харилцаа уялдаа нэгдмэл байдлыг хангах эрх зүйн орчныг сайжруулна.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид үзүүлэх төрийн дэмжлэгийн чиглэл шалгуурыг тодорхой болгосноор хөдөө аж ахуйд хөрөнгө оруулах сонирхлыг нэмэгдүүлж салбарын эдийн засгийн өсөлт экспортыг дэмжинэ.

Хөдөө аж ахуйн өртгийн сүлжээнд төр хувийн хэвшлийн иргэний нийгэм, мэргэжлийн байгууллага холбоодын хамтын ажиллагааг бэхэжнэ гэж үзэж байна. Иймд нэр бүхий Улсын Их Хурлын гишүүдээс санаачлан боловсруулсан Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл дагалдах хуулийн төслийг хэлэлцэж өгнө үү.

Д.Амарбаясгалан: Төслүүдийн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ухнаагийн Отгонбаяр уншиж танилцуулна. Индэрт урьж байна.

У.Отгонбаяр: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Улсын Их Хурлын гишүүн Мандхай нарын 10 гишүүнээс 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2025 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Хууль санаачлагч Хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогын суурь зарчмыг тодорхойлж, өртгийн сүлжээний нэмэгдэл, цогц байдлыг хангах, эрсдэлийн болон чанарын үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх, үйлдвэрлэл эрхлэгч, хөрөнгө оруулагчдыг дэмжих чиглэл, шалгуурыг тогтоох, бүртгэл, хяналтын нэгдсэн сүлжээний эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор уг хуулийн төслийг боловсруулжээ.

Хуулийн төсөл нь хөдөө аж ахуйн салбарын суурь харилцааг зохицуулах тул хуулийн төсөл батлагдсанаар улсын төсөвт ачаалал нэмэхгүй, төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдээс аливаа зардал нэмж шаардахгүй байна.

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийг D-parliament.mn цахим хуудсанд байршуулж, иргэд олон нийтийн саналыг авч байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Туваан төсөлд хөдөлмөрийн үнэлэмж, бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, хүний нөөцийг чадавхжуулах, малчдын залгамж халааг бэлтгэн мэргэшүүлэх, түүнчлэн хөдөө аж ахуйн салбарын бодлогын тогтвортой байдлыг ханган төрөөс үзүүлэх татаас, хөнгөлөлт урамшууллын асуудлыг холбогдох хууль тогтоомжтой уялдуулан боловсруулсан эсэх, Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар төсөлд хөдөө аж ахуйн салбарын эрсдэлийг бууруулах, цөлжилттэй тэмцэх арга хэмжээг тодорхойлон үйлдвэрлэлд инновац, технологийн дэвшлийг нэвтрүүлэх асуудлыг зохицуулсан эсэх, салбарын бодлого боловсруулах, төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах, хяналт тавих, хариуцлагын тогтолцооны асуудлыг тусгасан эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ганхүлэг хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж байгаа Цагаан алт, Хүнсний хувьсгал, Шинэ хоршоо, Чинээлэг малчин зэрэг хөтөлбөр цаашид тогтвортой хэрэгжих, хуулийн төсөлд энэ талаарх зохицуулалтыг тусгасан эсэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Туваан төсөлд салбарын бодлогыг цогц байдлаар хэрэгжүүлэх чиглэлээр дэвшилтэт санаа туссан боловч зарим асуудлыг хэлэлцүүлгийн явцад сайжруулах, хөдөө аж ахуйн салбар дахь төрийн удирдлага зохицуулалтад орон нутгийн байгууллагатай хамтран ажиллах зарчмын асуудлыг анхаарах, судалгаа шинжилгээг эрчимжүүлэх, санхүүжилтийн асуудлыг тусгах, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ уур амьсгалын өөрчлөлтийг сөрөн тэсвэрлэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг үнэлэн байгалийн тэнцэл алдагдахаас сэргийлж хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн болон бэлчээрийн газрыг хамгаалах чиглэлээр салбар дундын зохицуулалтыг уялдуулах, Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар үйлдвэрлэгч, малчдын орлогыг хамгаалах, төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагаа, оролцоог хангах, хяналт хариуцлагын тогтолцоог сайжруулах асуудалд анхаарах, хэлэлцүүлгийн явцад олон нийт,

эрдэмтэн судлаачдын саналыг тусган сайжруулах боломжтой тул хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн саналуудыг хэлсэн болно.

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Даваасүрэнгийн Есөн-Эрдэнэ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Цэвэгмэдийн Мөнхнасан Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Энхбаатарын Цолмонжаргал Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн ахлах референт, Балганы Алтанцэцэг НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын мэргэжилтэн, Дамдинсүрэнгийн Гүрбазар ХААИС-ийн Мал аж аху, биотехнологийн сургуулийн захирал, Хөдөө аж ахуйн ухааны доктор, Зоригтын Эрдэнэчимэг ХААИС-ийн Агроэкологийн сургуулийн багш, Хөдөө аж ахуйн ухааны доктор, Гүнэнгийн Сувдаа “Биотериал” компанийн эрдэмтэн, нарийн бичгийн дарга, Бадраагийн Одонхүү “Монголын Тариаланчдын үндэсний холбоо” ТББ-ын тэргүүн.

Одоо Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дарааллын дагуу асуулт асууна. Ирцийн дарааллаар Болдын Уянга гишүүн асуулт асууя.

Б.Уянга: Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Хөдөө аж ахуйн тухай хуулийг бол зарчмын хувьд дэмжиж байгаа. Тэгээд сая өнгөрсөн хэдэн өдрүүдэд Дорноговь аймгийн 5 сумдаар ажиллаж явахад бол бас энэ хуульд ер нь малчдыг дэмжих талаар яг тодорхой шийдэл бүхий заалтыг тусгасан эсэх талаар бол хэлэлцүүлгүүд өрнөсөн. Тэгээд яах вэ, энэ явцад нэг зүйлийг тодруулах хэрэгтэй байгаа. Бас Хөдөө аж ахуйн тухай хуулийг дагаад Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл явж байгаа. Тэгэхээр ер нь бол малын тоо толгойн албан татвар гээд бид нар авдаг. Тэгээд иргэдийн хурлаасаа шийдвэрлээд 0-2 мянган төгрөг толгой мал тутамд оногдуулаад авдаг байна. Төсвийн тухай хуульд болохоороо яг энэ албан татварыг эргээд юунд зарцуулж байгаа вэ гэхээрээ тухайн орон нутаг нь газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэргэжилтэй тэмцэх гээд бүр нэлээн тодорхой тусгаад өгчихсөн юм билээ.

Тэгээд зүгээр миний өнөөдөр асуух гээд байгаа зүйл нь танай ажлын хэсгээс энэ Хөдөө аж ахуйн тухай хууль дээр ажиллаж байхад ер нь жилд бид нар яг энэ санд хэчнээн төгрөг хуримтлуулаад байдаг юм. Малын тооллогын албан татвар гэж

манай улсын төсөвт хэдэн төгрөг байгаад, тэр нь эргээд хэр үр ашигтай зарцуулагддаг юм бэ. Энэ судалгаа хийгдсэн болов уу. Энэ дээр хариулт авъя.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Төсөл санаачлагч Мандхай гишүүн хариулт өгье.

М.Мандхай: Яг хамгийн сүүлийн 2024 оны байдлаар яг энэ малын тоо толгойн албан татвартай холбоотой жилд төсөвт хэдий хэмжээний төсөв тусгагдаж байгаа талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас албан ёсоор бас мэдээллийг өгсөн нь дээр байх. Одоогийн байдлаар жишиг дээд хэмжээ 1 толгой мал тутамд бол 2000-5000 төгрөгийг авч байгаа. Тухайн малчин өрхийн жилийн эцсийн мал тооллогын дүнг үндэслэж, энэ татварыг бол авдаг. Энэ татварын орлого бол өөрөө 100% орон нутгийн төсөвт төвлөрч байгаа. Ер нь бол мал аж ахуйг хөгжүүлэх, бэлчээрийн менежмент, усан хангамж, байгаль хамгаалал, малчдын амьжиргааг дэмжих чиглэлээр бол зарцуулах ийм эрхтэй байдаг. Би буруу хараагүй бол 2024 оны улсын хэмжээнд татварын орлого ойролцоогоор 65-70 тэрбум төгрөг гэсэн тоо харж байсан. Тэгэхээр Өмнөговь, Ховд, Хэнтий зэрэг малын тоо ихтэй аймгуудад бол хамгийн их татвар төвлөрүүлсэн статистик тоо бол байдаг. Тэгээд энэ дээр илүү баталгаажуулж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас асуултад хариулаад өгөөрэй.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. 4 дүгээр индэр. Өөрийгөө танилцуулаад, хариулт өгье.

Ц.Мөнхнасан: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Мөнхнасан. Болдын Уянга гишүүний асуултад хариулъя.

Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн дагуу бүрдсэн орлогыг сумын хөгжлийн санд төвлөрүүлж байгаа. Ер нь жилдээ 130 орчим тэрбум төгрөг улсын хэмжээнд цугларч байгаа. Тухайн сумдын ИТХ-аас аль төрлийн малд хэдэн төгрөгийн татвар ноогдуулснаас хамаараад улсын хэмжээнд сумдад дунджаар 50 орчим сая төгрөгийн орлого жилдээ бүрдэж байгаа. Энэхүү орлогыг ИТХ-ын шийдвэрээр буцаагаад саяын Төсвийн тухай хуулийн 62.8-д заасан 13 үйл ажиллагаанд зарцуулагдаад ингээд явж байгаа.

Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах босгох татварт малд ноогдуулах доод утгыг шинэчлэн тогтоох тухай хуулийн төсөл бас /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Уянга гишүүн тодруулж асууя.

Б.Уянга: Хүнс, хөдөө аж ахуйн яамныхан яг тэр татварын хэмжээ ч яах вэ тэгээд л тогтоодог л жамаараа тогтчих байх. Эргээд яг энэ Төсвийн тухай хуулийн дагуу зарцуулалт нь яг хийгдэж байгаа эсэх дээр хяналт тавьдаг уу л гэж ер нь бол асуугаад байгаа юм. Энэ талаар бас бичгээр мэдээлэл авчихъя гэж бодож байна. Тэгээд хамтарч ажиллахыг хүсье.

Д.Амарбаясгалан: Дүгэрийн Рэгдэл гишүүн асуулт асууя.

Д.Рэгдэл: Баярлалаа. Тэгэхээр Хөдөө аж ахуйн салбар онцгой чухал салбар. Энэ талаар хууль санаачилсан Мандхай гишүүд тэргүүтэй Их Хурлын гишүүддээ баярлаж байна. Энэ хуулийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Их чухал хууль учраас энэ дээр бас их анхаарч ажиллах шаардлагатай гэдэг ойлголттой байгаа. Тэгээд энэ хуулийн төсөлтэй холбогдуулаад 2, 3 санал хэлье.

1 дүгээрт энэ хууль дотор өөр хуулиудтай давхардсан, зөрчилдсөн заалтууд байгаа. Ялангуяа 15 дугаар зүйл Хөдөө аж ахуйн судалгаа хөгжүүлэлт гэдэг дээр. Энэ дээр энэ зөрчилдсөн заалтуудыг оруулж ирэх нь буруу юм байгаа. Яагаад ийм заалтууд оруулж ирээд байгаа юм бол гэж гайхаад байгаа.

2 дугаарт энэ хөдөө аж ахуйн салбарын дэмжлэгийн асуудлыг бол бас нэлээн анзаарч сайн оруулсан байна. Тэгэхээр зэрэг хөдөө аж ахуйн салбарын энэ хууль дээр бид нар хөдөө аж ахуйн салбарын өртгийн сүлжээний асуудлаараа бол их ач холбогдол өгсөн мөртөө хөдөө аж ахуйн салбарын үндсэн бүрдүүлэгч хэсэг болох мал аж ахуй маань энэ нүүдлийн соёл иргэншлийн өвийг авч явдаг. Бүр Монголд төдийгүй дэлхийд авч явдаг энэ салбар байгаа юм. Тэгэхээр энэ өв тээгчийн хувьд төрөөс өшөө ямар хэлбэрийн дэмжлэг үзүүлж болох юм бэ. 18 дугаар зүйл дээр байгаа 18.2.4 дээр бусад гээд хаячихсан. Энэ дотор багтаж явна гэмээргүй байна. Энэ өв тээдэг салбарыг төр өөр бодлогоор дэмжих ёстой. Мал аж ахуйг. Энэ тал дээр та бүхэн маань ямар саналтай байдаг юм бол.

3 дугаарт сая танилцуулга Байнгын хорооныхтой ч хэллээ. Хууль хэрэгжиж эхэлснээр батлагдсанаар ямар нэгэн төсвийн мөнгө төгрөгийн дарамт гарахгүй гэсэн юм хэлээд байгаа юм. Хуулийг бүхэлд нь уншаад үзэхээр бас тийм юм байхгүй. Тийм биш санагдаад байгаа юм. Миний ажигласнаар бол энэ хуулийг сайтар үзвэл 1 агентлаг шинээр байгуулах, салбарын судалгаа, хөгжлийн асуудал хариулсан төрийн байгууллага нэгийг байгуулах, төрийн үйлчилгээний байгууллага 1-ийг байгуулах, төрийн өмчит үйлдвэрийн газар шинээр 1-ийг байгуулах, төрийн өмч оролцсон хуулийн этгээд 1-ийг байгуулах, тэгээд аймгуудад судалгааны, хүнсний бус түүхий эдийн судалгааны 21 лаборатори байгуулах, тэгээд орон нутгийн төсөв дээр хүний нөөцөө бэлдэх зардлаа шийдэх гээд ингээд 6 төрлийн зардалтай холбоотой агуулга яваад байгаа юм. Тэгэхээр энэ хуулиар агентлаг байгуулдаг, хуулиар төрийн өмчит үйлдвэрийн газар байгуулдаг энэ бол манай Их Хурлын үйл ажиллагааны үндсэн зарчимтай харшилна шүү. Яагаад ийм олон юм шинээр байгуулах гээд энэ хуульдаа оруулж ирээд байгаа юм бэ гэж бүр зориуд асуумаар байгаа юм. Энэ ямар гээч агентлаг байгаад байх юм.

Тэгээд энэ чинь шинжлэх ухаан технологи дээр бол жишээлбэл салбар зөвлөлтэй байна гээд. Энэ бол Шинжлэх ухаан технологийн тухай хуульд угаасаа байж байгаа. Тэгээд салбар зөвлөл хурлаа хийгээд, гарсан шийдвэрийг сайддаа танилцуулна гээд байгаа юм. Шинжлэх ухаан, технологийн хууль дээр салбар зөвлөлөө сайд толгойлно гэсэн заалттай. Сайд толгойлно. Тэгэхээр сайд салбар зөвлөлөө толгойлох нь байна. Энэ тэр гээд иймэрхүү юмнуудыг бас сайн анзаармаар байгаа юм.

Тэгээд миний санал бол хуулийг яаралтай ажлын хэсэг байгуулаад, Их Хуралд хэлэлцүүлэхэд бэлтгэх ажлыг яаралтай эхлүүлэх нь зөв юм болов уу гэж бодож байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Мэндбаярын Мандхай гишүүн хариулт өгье.

М.Мандхай: Рэгдэл гишүүндээ баярлалаа. Бас хуулийн төсөлтэй бас нэлээн сайн уншиж танилцсан байна. Мэдээж Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлд бол судалгаа хөгжүүлэлтийн тухайд бол мэдээж судалгаа хөгжүүлэлтийн тогтолцоог бид нар бол сайжруулах шаардлагатай байгаа. Хөдөө аж ахуйн салбарт бол мэдээж дэвшилтэт технологи, инновац нэвтрүүлэх, мэдээж цаг үеийн хөгжилтэйгөө зэрэгцээд оюуны өмч хүртэл хамгаалагдах мэдлэгийн ийм эрэлтүүдийг оруулах, үүнийхээ дагуу бас хэрэгжүүлэх ийм шаардлага хэрэгцээ бол байгаад байгаа. Тэгээд таны санаа зовниж байгаа энэ шинэ шинэ байгууллага нэгжүүдийг үүсгэх, эргээд энэ нь өөрөө төсөвт зардал болж нэмэгдэх эрсдэл байгаа юу гэдэг асуултыг хэлье.

Бид нар бол энэ хуулийг одоо байгаа үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагууд дээр чиг үүргийн хувьд хооронд нь уясан ийм зохицуулалтыг оруулсан байгаа. Одоогийн байдлаар үндсэндээ 30 орчим яг энэ манай Хөдөө аж ахуйн салбарын дэд салбарыг зохицуулсан хуулиуд бол байгаа. Тэгээд энэ Хөдөө аж ахуйн тухай хууль бол өөрөө анхдагч хууль буюу малгай хууль гэж хэлж болно. Тэгэхээр энд ингээд шинжлэх ухааны зүгээс болон энэ төрийн дэмжлэгүүд, таны түрүүний бас хэлж байсан салбар агентлагийн чиг үүргийг л ер нь уялдуулах зохицуулалтыг оруулж өгсөн байгаа. Тэрнээс биш шинээр ямар нэгэн байгууллага нэмсэн асуудал бол байхгүй байгаа шүү гэдгийг бас хэлмээр байна. Тэгээд ажлын хэсгийн гишүүдээс илүү нарийвчлаад мэдээлэл өгнө.

Д.Амарбаясгалан: Хариулт болсон уу Рэгдэл гишүүн. Тодруулж асууя.

Д.Рэгдэл: Зарчмын хувьд дэмжиж байгаа. 1 асуудал дээр бас хариулт авмаар байгаа юм. Энэ малчид маань нүүдлийн соёл иргэншлийн өвийг тээж авч явдгийн хувьд бид нар малчдаа хамгаалж байх ёстой. Тэгэхээр төрөөс яг мал аж ахуйн үйлдвэрлэл дээр мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд тусгай дэмжлэг олгох бодлогыг энд хуульчилмаар байгаа юм. Тэгэхээр тусгай дэмжлэгийн тал дээр манай Хөдөө аж ахуйн яамныхан маань ер нь ямар санаа бодолтой байна вэ. Та нартай дараа нь бас би санал бодлоо хуваалцахад бэлэн байгаа. Тэр та бүхний санаа бодлыг энэ удаа би сонсож авъя гэж бодож байгаа юм.

Д.Амарбаясгалан: Мандхай гишүүн нэмж хариулъя.

М.Мандхай: Энэ Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих дэмжлэгийн тал дээр 18 дугаар зүйл дээр бас нэлээн дэлгэрэнгүй тусгасан байгаа. Төрөөс үзүүлж байгаа энэ дэмжлэгийг 4 төрөлд бид нар ангилж оруулсан байгаа. Шууд болон шууд бус татаас, тарифын болон тарифын бус зохицуулалт, хөнгөлөлттэй зээл, зээлийн хүүгийн хөнгөлөлт, бусад гэсэн ийм төрлүүд байгаад байгаа. Тэгээд таны түрүүн хэлсэн мал аж ахуйн салбар, ялангуяа малчдаас гарч байгаа түүхий эдийг үнэгүйдүүлэх биш дараагийн борлуулах худалдан авах өртгийн сүлжээ нь өөрөө тодорхой бус явж ирж байгаа энэ тулгамдаж байгаа асуудлуудыг бид нар энэ хуулиар маш дэлгэрэнгүй зохицуулж өгсөн байгаа. Тийм учраас малчид сум дээрээ байгаа түүхий эдийг жишээлбэл ноосоо хаяхгүй, дайвар бүтээгдэхүүнээ хаяхгүй, арьс ширээ хаяхгүй байх үүнийг нь аваад дараагийн өртгийн ... /минут дуусав/.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

М.Мандхай: Ийм учраас бид нар тухайн сум дээр түүхий эдийг нь хүлээж авах төвлөрсөн цэгийг хувийн хэвшлийн оролцоотойгоор бас байгуулахаар хууль дээрээ

тусгасан. Ингээд ирэхээр төрөөс үзүүлж байгаа нөгөө дэмжлэг чинь илүү чанар, аюулгүй байдлыг хангасан өртгийн сүлжээний оролцогчдод тавигдаж байгаа шаардлага хангасан, баталгаажуулсан түүхий эдийг аваад, эргээд энийгээ эдийн засгийн эргэлтэд оруулаад явах ийм боломжуудыг бас бүрдүүлж өгч байгаа. Тэгээд манай яг энэ хуулийг бас яг боловсруулсан эрдэмтэн, судлаачид бас яг энэ дээрээ дэлгэрэнгүй мэдээллийг бас өгөөрэй. Мөн яамнаас асуусан. Тэгээд яамныхан бас төрийн дэмжлэгтэй холбоотой асуултаа хариулаад өгөөрэй.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан гишүүн асуулт асууя. Уучлаарай Хөдөө аж ахуйн яамнаас нэмж хариулт өгье. 4 дүгээр индэр.

Г.Сувдаа: Сувдаа. “Биотериал” ХХК-ийн эрдэмтэн, нарийн бичгийн дарга байна. Хуулийн ажлын хэсэгт ажилласан. Тэгэхээр мал аж ахуй бол угаасаа Монголын үндэсний уламжлал, өв соёлыг тээж байгаа. Дэлхийн хүн төрөлхтний өмнө бас үүрэг хүлээсэн ийм салбар. Тэгээд Малчны тухай хуулиар Улсын Их Хурлаас баталсан хууль дээр малчныг дэмжих асуудлыг нэлээн сайн зохицуулж өгсөн байгаа. Тэгэхээр энэ дээр бол мал аж ахуйн хөгжлийн сан байгуулах, мөн түүнчлэн малчныг сонсох өдөртэй байх, сум бүр дээр малчны тэнхимтэй буюу малчны хөгжлийн төвийг байгуулах гэх мэтчилнээр яг Малчны тухай хууль дээрээ зохицуулчихсан учраас Хөдөө аж ахуйн тухай хууль дээр давхардуулахгүйгээр яг малчны холбоотой харилцааг нь Малчны тухай хуулиар зохицуулна гээд тусгасан байгаа. Тэгээд нэмж мэдээж малгайн хуульдаа оруулах асуудлыг бид дараагийн ажлын хэсэг .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Мандхай гишүүн үү. Хэн нэмж хариулах юм. Мандхай гишүүн нэмж хариулъя.

М.Мандхай: Мөн энэ 18.6.3 дээр “гарааны бизнес болон орон нутгийн хөгжлийн төвүүдэд хөдөө аж ахуй, хүнс үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр логистикийн цогцолборыг кластераар хөгжүүлэх, мөн хувийн хэвшлийн болон хоршоодын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар тусгасан байгаа. Эдгээр үйл ажиллагааг явуулахад төрөөс үзүүлж байгаа дэмжлэг өөрөө яг эдгээр үйлдвэрлэлүүдийн чиглэлээр энэ түрүүний 4 ангилалд дэмжих энэ боломжийг бас оруулж өгч байгаагаараа малчдад бас ийм давуу талыг үүсгэх юм.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан гишүүн асуулт асууя.

Ц.Туваан: Бүгдэд нь энэ өглөөний мэнд хүргэе. Энэ Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл анхдагч хууль гээд энэ хуулийн төслийг бол дэмжинэ. Манай хөдөө аж ахуйн салбарт бас маш олон хуулиуд, Их Хурлын тогтоол гээд маш олон эрх зүйн бичиг баримтууд байдаг. Тэгэхээр тэд нарын малгай болох хууль бол зайлшгүй хэрэгтэй байгаа гэж ингэж ойлгож байгаа. Үндсэн хууль тэгээд органик хууль, бусад хууль гээд явдаг шиг ийм малгай хууль энэ салбарт зайлшгүй хэрэгтэй болоод байгаа юм. Тэгэхээр дэмжиж байгаа. Тэгэхдээ энэ дээр бас нэлээн судалж үзэх, анхаарах ийм асуудлууд байгаа учраас ажлын хэсэг байгуулагдаад, тэр ажлын хэсэг дээрээ бас нэлээн засаж сайжруулах юмнууд байгаа гэж ингэж бодож байна. Энэ салбарт Монгол Улсын хамгийн их ажиллах хүчнийг шингээж байгаа ийм салбар. Газар тариалангийн салбар, мал аж ахуйн салбар, хөнгөн, хүнсний үйлдвэрлэлийн салбар гээд нийлээд бараг 350, 360 мянган хүний асуудал энд хөндөгдөж байгаа. Тэгэхээр энэ дээр бол салбар салбар дээр энэ асуудлууд бол чухал байгаа.

Мал аж ахуйн салбар дээр гэхэд малчдын залуу халаа гэдэг юм бол байхгүй болсон. Одоо хөдөө мал дээр хэн байна. Хэдэн тэтгэврийн насны ахмадууд, хөгшчүүд, тэгээд байгаа нь ганц бие залуучууд. Гэр бүл байхгүй. Тэгээд гэр бүлтэй нь бол 9 сарын 1 болоод хичээл эхэлсэн, хүүхдээ аваад сумын төв дээр 6 настай хүүхдээ хараад байж байгаа. Тэгэхээр тэнд бол гэр бүлийн халуун дулаан уур амьсгал, гэр бүлийн асуудал бол нэн хүнд болсон. Тэгэхээр энэ малгай хууль юм бол энэ дээр тэр Малчны тухай хуультайгаа уялдуулж энэ асуудлыг зайлшгүй ярихгүй бол хэдэн жилийн дараа бид хэд нөгөө яриад байдаг малчингүй болно.

2 дугаарт мал аж ахуйн салбар дээр малын эмч, малын зоотехникч гэдэг хүмүүсийн дундаж наслалт одоо тэтгэврийн насыг давчихсан явж байгаа шүү. Сурч байгаа хүн байхгүй. Цалин цавуу бага, нийгмийн асуудал нь шийдэгдэхгүй учраас тэнд очиж ажиллах хүсэлтэй хүн байхгүй. Ингээд яах юм. Одоо тэтгэвэртээ гарсан хэдэн малын эмч нар, сумын, багийн малын эмч гээд хэдэн хүмүүс л байна. Нас өндөр болсон. Тэгээд сумдын Хөдөө аж ахуйн тасагт, Мал эмнэлгийн тасагт ажилладаг хүнгүй болсон. Орон тоо нь онгорхой, дээрээс нь зарим 1 хүнд нь давхар гүйцэтгүүлэх нэртэй цалингийн 40 хувийг нь өгөөд л байж байгаа. Тэгэхээр ийм асуудлуудыг бол нэлээн анхаарах цаг болсон.

Газар тариалангийн салбар дээр мөн механикжуулагчид байхгүй, агрономчид бас насны асуудалд орсон. Дээрээс нь газар тариалангийн салбар маань энэ жил байгалийн давагдашгүй хүчин зүйл ганд нэрвэгдсэн. Одоо дээшээ тэнгэр хол, доошоо газар хатуу л байна. Маш их зээл авсан. Тариаланчид ногоочид маань. Зээлийн асуудал дээр бид нар цаашдаа ямар бодлого барих юм. Тэр авсан зээлийнх нь ийм асуудал онцгой нөхцөл байдал, ган зуд үүсвэл давагдашгүй хүчин зүйлийн үед тэр асуудлыг нь шийдэж өгдөг зүйлийг энэ хуулийн зохицуулалтад оруулмаар байгаа юм. Ядахдаа энэ зээлийг нь хойшлуулаад хүү дээр нь бид нар хөдөө аж ахуйн салбарт нэлээдгүй татаас, урамшуулал өгч байгаа. Энэ жил 300 гаруй тэрбум төгрөг байх шиг байна лээ төсөв дээр. Тэгэхээр эндээс газар тариалангийн салбарынхан дээр энэ жил энэ хүүгийн татаас олгох, зээлийг нь хойшлуулах ийм асуудлууд байх уу, үгүй юу гээд. Тэгэхээр энийг бид нар энэ анхдагч хууль дотроо тусгаж өгмөөр байгаа юм.

Тэр томилгооны асуудал чухам яаж орж ирж байгаа юм. Аймгийн Засаг дарга нар үгээ хэлж маш олон хүн ярьж байгаа. Бид нарт хамаарч ажилладаг төрийн албан хаагчид байхгүй болсон шүү гэдэг зүйл хэлж байгаа. Тэгэхээр Хөдөө аж ахуйн тасаг, Хөдөө аж ахуйн газартай холбоотой томилгооны асуудал энэ хуульд чинь яаж туссан бэ гэдэг/минут дуусав/

Д.Амарбаясгалан: Мэндбаярын Мандхай гишүүн хариулт өгье.

М.Мандхай: Туваан гишүүндээ баярлалаа. Маш чухал асуудал, малчидтай холбоотой асуултуудыг хөндлөө. Ер нь бол нөгөө малчныг сургах, хөгжүүлэх, туршлага солилцох ч гэдэг юм уу, залгамж халаад бэлдэх асуудал бол өөрөө Малчны тухай хуульд бол нэлээн нарийн зохицуулалтуудыг бол оруулж өгсөн байдаг. Гэхдээ яах вэ, бид нар энэ малчны хөгжлийн бас төвтэй байх, малчныг сонсох өдөр, насан туршийн боловсрол олгох сургалтын төв болон сувгаар дамжуулан мэдлэг олгох, чадавхжуулах, тусгагдсан асуудлуудыг бол энэ хуулийн төсөлд бас оруулж өгсөн. Мөн 14.9 дээр харах юм бол хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн албан болон албан бус сургалтаар боловсрол эзэмших мөн бие даан суралцахад мэдээллээр ханган зөвлөх, туслах, мэргэшүүлэх чиг үүргийг бас яг энэ

хуульдаа нарийвчлан тусгасан байгаа.ер нь бол аль болох мэдээж мэргэжлийн бус чиглэлээр суурь энэ малчны энэ зохистой дадал, дээрээс нь эдийн засгийн эргэлтэд өөрийнхөө малыг оруулахын тулд малчин өөрөө бэлэн байх энгийн суурь сургалтуудыг аль болох бид нар тухайн орон нутагт байгаа мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Насан туршийн төв, мэргэжлийн холбоо зэрэг энэ байгууллагуудыг түшиж хэрэгжүүлэхээр бол нарийвчилж тусгасан байгаад байгаа.

Дараагийн асуудал бас яг адилхан. Хүний нөөц бэлдэхтэй холбоотой. 14 дүгээр зүйл дээр хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хүний нөөц гээд бүр нэлээн тусгай бие даасан заалтыг бас тусгаж оруулсан байгаа. Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн зорилтыг шийдвэрлэхэд шаардагдах мэргэшсэн хүний нөөцийн хэрэгцээг мэргэжил, мэргэжлийн түвшнээр нь урт дунд хугацаанд тодорхойлж, хэрэгцээг хангах. Бид бас дээрээс нь яг эрэлт хэрэгцээнийхээ хөдөө аж ахуйн зах зээл, эрэлт хэрэгцээгээ харж байж эрэлт хэрэгцээний судалгаа хийгээд, судалгаанд түшиглэсэн тэр мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх ажлуудыг ХААИС мэргэжлийн байгууллагуудтай хамтарч байгаад ингээд сургалтын хөтөлбөр гаргаад, хүмүүсээ чадавхжуулах ажлуудыг бол ер нь эхлүүлээд явж байгаа. Гэхдээ энийг бас хуульчилж өгч явахгүй бол бас нөгөө хуулиас гадуур зохицуулалтгүй явж ирж байгаа учраас хуульчлаад өгчих юм бол эрэлт энэ судалгаанд түшиглэсэн шаардлагатай боловсон хүчнийг бэлдэх асуудлыг энэ хуулиар бас тусгаж оруулж өгсөн байгаа. Газар тариалантай холбоотой нарийн асуудлыг манай ажлын хэсгээс хариулна.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгээс 4 дүгээр индэр. Туваан гишүүн тодруулж асууя.

Ц.Туваан: Гантай холбоотой нөгөө тариаланчдын зээлийн хүүгийн татаас болон зээлийг хойшлуулах асуудал дээр ярьсан. Энийг хариулаад өгчхөөрэй. Тэгээд түрүүн бас тэр томилгоотой холбоотой бүтэц босоо байхтай холбоотой юм энэ хууль байна уу, үгүй юу. Тэрийг асуучихмаар байна. Тэгээд сая хууль санаачлагч Мандхай гишүүн хэлж байна. Малчны сургалт, сан гээд. Ер нь бол орлогын л асуудал. Одоо махны үнэ. Бид хэд нөөцийн мах гэж бэлдээд махны үнийг барьдаг. Ноолуурын үнэ хуучинтай харьцуулахад ам.доллароор харьцуулаад үзэхэд бага байгаа. Арьс шир огт үнэгүй байгаа гээд орлого талынх нь асуудлыг нь хэдүүлээ энэ малгай хуульдаа тусгаад шийдээд өгвөл хүссэн, хүсээгүй тэнд орлого олж байвал малчид тэнд очиж амьдраад орлогоо олоод, малаа маллах юм. Тэгэхээр энийг л яриад байгаа юм. Тэгээд тодруулсан асуултдаа хариулт авъя.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. 4 дүгээр индэр.

Э.Цолмонжаргал: Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн ахлах референт Цолмонжаргал. Гишүүний асуултад хариулъя. Одоогоор 21 аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын удирдлага, даргыг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга томилж байгаа. 330 сум, мал бүхий 6 дүүрэгт нийт ажиллаж байгаа Мал эмнэлгийн тасаг нь өөрөө сумын Засаг даргын Тамгын газрын доторх бүтцийн нэгж учраас Засаг даргын Тамгын газрын дарга томилж байгаа. Эдгээр мал эмнэлгийн тасгийн даргыг аймгийн Хөдөө аж ахуйн газрын дарга томилох боломжгүй. Яагаад гэвэл энэ өөрөө сумын Засаг даргын Тамгын газрын бүтцэд байдаг нэгж. Энийг хэрвээ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга томилдог болъё гэвэл энэ тасгийг бие даасан байгууллага болгож, 330 сум, мал бүхий 6 дүүрэгт .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 4 дүгээр индэр гүйцээж хариулъя.

Э.Цолмонжаргал: Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга нь сумын Хөдөө аж ахуйн тасгийн даргыг томилно гэвэл энэ нь бүтэн байгууллага байгуулах болчихно. Яагаад гэвэл томилгоо нь өөрөө сумын Засаг даргын Тамгын газрын доторх бүтцийн нэгжийн даргыг дээрээс нь аймгаас томилох боломжгүй учраас. Тэгэхээр хуулийн төсөлд одоогийн байгаа байдлаар нь тусгаад явж байгаа. Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргыг нэгжийн хуульд заасны дагуу аймгийн Засаг дарга томилох томилгоотой хэвээрээ явж байгаа.

Д.Амарбаясгалан: Энэ нөгөө том хуулиуд батлагддаг. Түрүүн Рэгдэл гуай бас тодорхой хэлж байсан. Үндсэн гол зохицуулалт хийдэг хуулиудтайгаа зөрчилдөөд, шинэ батлагдаж байгаа хууль хэрэгжиж чадахгүй байна гээд. Саяхан би бас ахмадуудтай уулзалт хийгээд явж байхад Ахмадын хууль батлагдаад хэрэгжиж эхэлсэн мөртөө яг тодорхой зүйл заалтууд нь тухайлбал төсөвтэй холбоотой асуудлаар төсөвт байгууллагуудаас бас тодорхой хувь хэмжээг ахмадын хөгжилд зориулах ёстой гээд заалт орчихсон мөртөө хэрэгжихгүй байна гэдэг асуудал гарч байгаа юм. Тэгээд яг цаг нь тулаад ирэхээр Сангийн яам бид Төсвийн тухай хуулиа барина гээд бусад хуулиудад байгаа заалтуудын хэрэгжилтийг хангахгүйгээр явчихдаг ийм л байдал байгаа юм. Яг үүнтэй адилхан энэ Хөдөө аж ахуйн хуулийг бас их олон талаас нь сайн ярилцах хэрэгтэй шүү.

Хуулийн гол зорилго маань албан тушаалтны томилгоо гэхээс илүүтэйгээр Мал аж ахуй, хөдөө аж ахуйн салбар явал төрөөс үл хамааралтайгаар зах зээлийн зарчмаар хөгжих ёстой юм бэ гэдэг энэ боломжийг л гаргаж өгөх хэрэгтэй. Сая Туваан гишүүн бас зээлийн асуудал асууж байгаа юм. Мэдээж гамшиг тохиолдоно, зудын эрсдэлээс үүдээд хөрөнгөө алдаж байгаа малчдад төр засаг тусламж дэмжлэг үзүүлэхээс өөр аргагүй нөхцөл үүсдэг. Гэхдээ байнгын татаастай явдаг тийм салбар болгох бодлогыг төр ерөөсөө байлгаж болохгүй. Харин бие дааж өөрөө өөрсдөөрөө хөгжих тэр боломжийг нь малчдад бүрэн гаргаж өгөх ёстой. Тэр ч агуулгаар шинэ хоршоо хөдөлгөөнийг санаачилж хөнгөлөлттэй урт хугацааны зээл авч малчид өөрсдөө өрхийн аж ахуй эрхлэх тэр боломжийг нээж өгөх бодлого бол ингээд үргэлжлээд явж байгаа.

Зүгээр сүүлийн өдрүүдэд улс төрийн шалтгаанаар Шинэ хоршоо хүндэрсэн мэт ярьж байна. Гэтэл өнөөдөр Монгол Улсад арилжааны банкнуудад эргэн төлөгдөж байгаа зээлийн хамгийн өндөр чанартай зээл нь Шинэ хоршоо, тэтгэврийн зээл, цалингийн зээл гэдэг зээлүүд ороод явж байдаг. Тэгэхээр ерөөсөө энийг бол ипотекийн зээл бас орж байдаг. Гэтэл энийг бид төрөөс хамааралтай байлгах бодлогыг хэрэгжүүлээд байдаг энэ явдал бас их буруу юм шүү. Төрийг цомхон байлгана гэдэг бодлогыг бид бүгд ярьдаг. Гэхдээ бодитой хэрэгжүүлж чаддаггүй. Тухайлбал иймэрхүү салбарын бодлогын асуудлыг салбарын яам мэдээж гаргаж байгаа. Хэрэгжилтийг хувийн хэвшлийн оролцоотойгоор хийх бүх нөхцөлийг хангах ёстой шүү дээ. Өндөр хөгжилтэй улс орнуудын жишгээр өнөөдрийн бидний хөдөлмөр, халамж үйлчилгээний бодлогыг хэрэгжүүлж байгаа агентлагийн ажлыг жишээлбэл Франц улсад хувийн компани хэрэгжүүлээд сууж болж байна. Яг ийм байдлаар бид энэ төрийн ачааг багасгаж, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, илүү шударга байх тэр боломж дээр анхаарах хэрэгтэй. Туваан сайд энд жишээ нь тэтгэврийн зээлийг тэглэнэ гээд л өчнөөн асуудал үүсээд бид тухайн үед бас тэглээд л явж байсан шүү дээ. Гэтэл тэр 850 тэрбум төгрөг өнөөдөр Монголбанкны алдагдал болоод л бичигдчихсэн явж байгаа шүү дээ.

Малчны зээлтэй холбоотой асуудлыг яриад л бид тэглэнэ гээд л улс төр хийгээд л попроод л явах юм бол үүний чинь үр дүнгээр ахиад л Монголбанкны алдагдал нэмэгдээд л сууж байх л нөхцөл рүү орчхож байгаа байхгүй юу. Тэгэхээр бид аливаа хуулийг гаргахдаа илүү их зах зээлийг нь дэмжсэн, өөрсдөө бизнесээ хийх, илүү өргөжиж хөгжиж дэвших тэр боломжийг бий болгосон тэр боломжийг бий болгосон хуулиудыг л гаргах нь зүйтэй. Ялангуяа энэ Хөдөө аж ахуйн салбарыг босгоё гээд салбарын яам, салбарын сайд энэ дээр нэлээн өндөр ач холбогдол өгөөд явж байгаа үе дээр өшөө илүү либерал бодлогыг л хэрэгжүүлэхэд анхаарах хэрэгтэй гэдгийг бас хэлмээр байна.

Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя. Алга байна. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуулт асууя.

М.Ганхүлэг: Гишүүддээ өдрийн мэндийг хүргэе. Хөдөө аж ахуйн салбарын хувьд бас Үндсэн хууль гэж хэлж болохоор ийм бас анхдагч суурь хуулийг бид бүхэн бас ярьж байна. Тэр агуулгаараа бас Ерөнхий асуултаас асуултаа эхэлье.

Энэхүү хуулийн гол хэлэлцүүлгүүд ямар ямар түвшинд хийгдсэн бэ. Хэчнээн судлаач эрдэмтэд ажлын хэсэгт болон тодорхой энэ хуулийн агуулга дээр бас ажилласан бэ. Миний санахын хуулийн төслийн гол агуулга нэлээн олон жилийн өмнө бас хийгдээд, орж ирэхгүй бас нэлээн хугацаа бас болсон. Тэгэхээр тэр суурин дээр үндэслээд явж байгаа байх гэж бодож байна. Хэчнээн малчид саналаа өгсөн юм. Хэрвээ тоо баримт юмнууд байгаа бол энийг илүү тариаланчид, аж ахуйн нэгжүүд, мэргэжлийн холбоод салбар яамны бас байр сууриуд Үндсэн яг энэ хуульдаа ямар байдлаар тусаж байгаа вэ гэдэг бол их хамгийн чухал асуудал болов уу гэж би бас бодоод байгаа юм. Тэгэхээр энэ чиглэлүүдээр тодорхой оролцсон хүмүүс болон ирсэн бичгүүд байгаа бол та бүхэн бас хариулаач ээ.

Би бас өргөн барьсан гишүүдийн нэг учраас ерөнхий ойлголтуудтай байгаа. Гэхдээ дэлгэрүүлээд саяын Их Хурлын даргын бас хэлж байгаа өртгийн сүлжээний яг аль хэсгүүд дээр ер нь төр оролцох ёстой вэ. Ер нь юу цаашлаад яг бие даасан байдлаа хангаад явахад ямар байх вэ гэдэг дээр бас дэлгэрүүлээд хариулаад явчих нь зөв байх. Миний үндсэндээ туршлага, саналаар бол хамгийн анхан шат дээр болон экспортын болон хамгийн сүүлийн шат дээр тодорхой дэмжлэгүүдийг үзүүлэх агуулгууд бас илүү байх нь зөв болов уу гэсэн ийм саналтай байгаа.

Мал эмнэлгийн үйл ажиллагаа гарал үүсэл талаасаа мөн экспортын хамгаалагдсан аж ахуй тодорхой бүс нутгийг хөгжүүлэх, хорио цээрийн бүс байгуулах талаас нь бол яалт ч үгүй төрийн оролцоо бол чухал байгаад байгаа. Тэгэхээр иймэрхүү яг экспортыг дэмжсэн өртгийн сүлжээний тодорхой цэгүүд дээр аль аль хэсгүүд дээр нь оролцож байгаа вэ гэдэг энэ агуулгыг бас боломжтой бол дэлгэрүүлээд хэлчих нь зөв байх.

Тогтвортой санхүүжилттэй холбогдолтой бүлгүүд бас байна лээ. Санхүүжилтийн үйл ажиллагааг бас хэт туйлширч болохгүй. Нэг талдаа дэмжлэг өгөх нь зөв гэж хэт туйлшраад, төрөөс хамааралтай салбар болгож болохгүй. Нөгөө талдаа бие даах ёстой, бусад салбартайгаа адилхан байх ёстой гэдэг байдлаар бас хандаж болохгүй. Тийм учраас тогтвортой, зүй зохистой энэхүү санхүүжилтийн агуулгыг бас энэхүү хууль дээр яаж оруулж байгаа вэ гэсэн.

Боловсон хүчинтэй холбогдолтой асуултыг бол сая асуучихлаа. Салбар яамны хувьд бас нэлээн эмзэглүүштэй асуудал нь зөвхөн газар тариалан, мал аж ахуйн салбараас гадна салбарын яг бас мэргэжлийн боловсон хүчин маш хүндрэлтэй болчихсон байгаа. Мянга гаруй орон тоо дээр 50, 60 хувьд нь л үндсэндээ яг салбарын анхан шат дээр мэргэжилтнүүд маань ажиллаж байна. Үлдсэн хэсэг нь бүрдэх, хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагааг Монгол орон даяар явуулах энэ төрийн үйлчилгээг бас хүргэх чиглэл дээр энэхүү хууль батлагдсанаараа тодорхой үр дүнгүүд бас гарах боломжууд гарах уу гээд ийм асуудлуудыг илүү дэлгэрүүлж асууя.

Д.Амарбаясгалан: Мэндбаярын Мандхай гишүүн хариулт өгье.

М.Мандхай: Ганхүлэг гишүүнд баярлалаа. Энэ хуулийг бас хамт өргөн барьсан учраас энэ хуулийн талаар нэлээн сайн мэдээлэлтэй байгаа. Ер нь бол бид нар 4 сарын 15-ны өдөр D-Parliament-д санал байршуулсан Ойролцоогоор 100 орчим бичгээр D-Parliament цахим дээр бол саналууд ирсэн байгаа. Үүнээс гадна бид нар 2 удаагийн албан ёсны хэлэлцүүлгүүдийг фермер, малчид, мэргэжлийн холбоод болон яам, агентлагуудын түвшин, төрийн байгууллагуудын түвшинд өрнүүлсэн. 3 дахь хэлэлцүүлгийг бол гишүүдийн дунд бас өрнүүлж нэлээн бас асуулт, саналуудыг бол хүлээж авсан байгаа. Ойролцоогоор бол нийт 50 гаруй асуултууд яг мэргэжлийн түвшин малчид, фермерүүдийн дунд хийсэн хэлэлцүүлгээр 50 гаруй асуултууд ирсэн. 101 саналууд бол ирсэн байгаа. Тэгээд манай бас экспертүүд бол тэр нарийн яг хэдэн хувьд нь фермер малчдын саналууд ирсэн байна. Мэргэжлийн холбоод гэдгийг нь шүүгээд бас гаргаад хариултаа бэлдэж байгаарай гэж хэлмээр байна.

Сүүлийнхээс нь эхлээд асуултад хариулъя. Энэ хууль дээр тогтвортой санхүүжилттэй холбоотой асуудал бол хэд хэдэн зохицуулалтаар бол туссан байгаа. Жишээлбэл, мэдээж улсын төсөв, орон нутгийн энэ хөгжлийн сан, Хөдөө аж ахуйн сангаас тогтмол санхүүжилт олгож байгааг илүү төлөвлөлттэй орон нутаг дээр хөдөө аж ахуйн хөгжлийн хөтөлбөртэй байх. Энэ хөгжлийн хөтөлбөрөөрөө дамжуулаад, орон нутгийн ялангуяа энэ орон нутгийн хөгжлийн сан болон энэ сангуудаас дамжуулаад яг энэ төлөвлөгөөнд нь тусгаж, хөрөнгө оруулалт хийдэг байх, дэмжиж ажилладаг байх, газар зохион байгуулалтын холбоотой асуудлуудыг нарийвчилж бас оруулсан.

Мөн гадаадын зээл буцалтгүй тусламжийг бол илүү салбарын зорилтот төсөл хөтөлбөртэй бас уялдуулах, хөнгөлөлттэй зээл татаас, зээлийн хүүгийн дэмжлэгийг бол бас энд хуульчилсан байгаа. Ялангуяа мал аж ахуй, газар тариалан боловсруулах үйлдвэрлэлд түлхүү чиглүүлэх, дотоодын үйлдвэрлэлийг илүү хамгаалах зорилготой энэ төрийн дэмжлэгүүдийг тусгаж оруулсан байгаа. Мөн санхүүжилтийг зөвхөн урсгал дэмжлэг бус илүү инновац, судалгаа, дэд бүтэц, хоршоо, кластер зэрэг дээр төвлөрч, бүтээмжийн өсөлтөд чиглүүлэх талаар бол хуульдаа тусгасан.

Төрийн оролцооны тал дээр бол төрийн оролцооны түвшин энэ хуульд бол нэлээн өргөн цар хүрээтэйгээр бол оруулсан байгаа. Жишээлбэл бодлогын түвшинд гэхэд хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хуулийн хэрэгжилтийг бас удирдаж ажиллах, сайд дэргэдээ бас энэ зөвлөлөөрөө дамжуулж ажиллах, санхүүгийн түвшинд бол төрөөс татварын бодлогоор дэмжлэг үзүүлэх,

илүү хөнгөлөлттэй зээл олгох, хүүгийн татаасыг төрөөс хариуцах, импорт, экспортын зохицуулалт гээд нэлээн өргөн хүрээнд ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Мандхай гишүүн гүйцээж хариулъя.

М.Мандхай: Эрсдэлийн бас удирдлага түрүүн Туваан гишүүн бас асууж байсан. Энэ дээр нэмээд төрөөс яг ямар оролцоотойгоор дэмжиж ажиллах вэ гэхээр эрсдэлийн удирдлага буюу газар тариалан хэрэв ган зудтай нөхцөл байдал дээр энэ эрсдэлийг яах юм бэ гэдэг асуудлуудыг бид нар бас хуульдаа зохицуулалтыг хийж өгсөн байгаа. Ган зудын үед бол илүү отор, өвс тэжээл, усан хангамжийн арга хэмжээг бол зохицуулна. Мэдээж түүхий эдийн тулгамдаж байгаа эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх асуудал дээр бид нар аль болох үйлдвэрлэлийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, удирдлагын нэгдсэн тогтолцоог хэрэгжүүлнэ. Эрсдэлийг бол байгаль орчин, эдийн засаг, нийгмийн гэсэн эдгээр бас яг арга хэмжээ дээр үндэслэж, төрөөс олгох гэж байгаа дэмжлэгүүд нь түлхүү түрүүлж дотоодын үйлдвэрлэл, энэ үйлдвэрлэлийг хамгаалах чиглэл рүү тусгана. Хөдөө аж ахуйн дотоодын үйлдвэр .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Даваасамбуугийн Ганмаа гишүүн асуулт асууя.

Д.Ганмаа: Сайн байцгаана уу. Энэ хуулийг ийм том малгай, суурь ч гэж хэлж болох анхдагч хуулийг бол дэмжиж байгаа. Бид нарт яах аргагүй зайлшгүй шаардлагатай, хэрэгтэй хууль. Энэ хууль гарч байж бас бусад хуулийн уялдаа хангагдах нөхцөл бүрдэнэ гэж тийм ойлголтыг ажлын хэсгээс би авсан. Үүнтэй холбоотой юу гэдэг юм эхний ядаж яагаад хэрэгтэй гэдэг нь food security, food safety гэдгээ ядаж л ялгаж салгаж тодорхойлолт нь тодорхой болох юм байна лээ. Үүнтэй холбоотой хэдэн асуулт байгаа.

1 дүгээрт 2012 оных байх, Хүнсний тухай хууль, Хүнсний аюулгүй байдлын хууль. Хуулийн хэрэгжилт 27, 40 хувь гээд харьцангуй их бага байгаа гэсэн. Энэ хууль нь Хүнсний баяжуулалтын хуультайгаа ямар уялдаа холбоотой явах вэ гэдэг дээр асуулт авмаар байна.

2 дугаарт энэ 16 дугаар хэсэг дээр хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эрсдэл түүнээс урьдчилан сэргийлэх гээд байгаль орчин, эдийн засаг, нийгэм гэж явж байснаа эрүүл мэндийн эрсдэл тэрнээс урьдчилан сэргийлэх гэдэг асуудал хаягдчихсан байна. Хүнс гэдэг бол яг агаар шиг сайн дураараа хүн амандаа хэрэглэж амандаа оруулж байгаа шингэн ч бай, хуурай ч бай эдгээр шим тэжээл бодисууд. Энэ дээр яагаад эрүүл мэндийн асуудал орж ирдэггүй вэ. Жишээлбэл, аплоктоксин гээд элэгний юу гэдэг юм hepatitis тэгээд элэгний хавдар болохоор энэ үр тариа хадгалахад ийм мөөгөнцрийн хордлогоос удаан хадгалалтын ийм хор байгаа шүү дээ. Бүр токсин гэж нэрлэдэг. Эсвэл жоохон байж байгаад л олон нийтийг хамарсан хордлого явагддаг тийм үү. Сургууль, цэцэрлэг бүүр эмч нар дээр ч гэсэн. Эдгээр асуудлыг яаж урьдчилан сэргийлэх юм. Эрсдэлийг нь яаж тодорхойлох юм. Энэ ажлын хэсэг дээр чинь нийгмийн эрүүл мэнд юм уу эмч, эмнэлгийн төлөөллүүдээс орж ажилласан уу. Энийг яг хамгаалахын тулд.

3 дугаарт эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эндээс ерөөсөө салгаж болдоггүй. Манайх бараг л нөгөө бүгдээрээ Африкийн орон гэж тодорхойлоод байдаг. Одоо бусад бүх орон бараг мэдээллийн сантай. Эрүүл мэнд дээр хоол хүнсээрээ авснаараа бид нар ямар шим тэжээлийг авч чадаад байгаа юм. Тэгээд

ямрыг нь авч чадахгүй байгаа юм. Юу дутагдалтай байгаа юм. Энэ мэдээллийн сан дээр хийсэн эсвэл энэ хууль дээр тусгасан юмнууд байгаа юу. Хэр зэрэг сайжруулах гэж байгаа вэ. Бид нар нөгөө Харвардын багтай нийлээд 2012 оноос 8 жилийн хугацаанд энэ яг насанд хүрсэн хот хөдөөгийн эрэгтэй, эмэгтэй хүмүүст зориулсан мэдээллийн сан бий болж, тухайн үеийн салбарын сайдууд, тэнхим бүх хүмүүст тайлбартай, ойлголттойгоор энийг улс цааш нь үргэлжлүүлээд аваад яваач гэсэн уулзалтуудыг хийж байсан. Хүүхдийнх ч юм уу эсвэл эхчүүдийн гэдэг мэдээллийн санг хэр зэрэг явуулж байгаа вэ. Энэ дээр ер нь энэ хууль дээр тусгасан, хуулийн ажлын хэсэгт ажиллаж байсан хүмүүс гэсэн энэ дээр байгаа байх гэж бодож байна.

4 дүгээрт ер нь энэ эрүүл мэндээ яагаад яриад байгаа вэ гэхээр One health гэсэн ойлголт 1986 оноос хойш гарч ирсэн. Юу гэсэн үг вэ гэхээр ургамал амьтан хүний эрүүл мэнд уялдаатай нэг орчиндоо явна. Одоо жишээлбэл бид нар амьтны эрүүл мэнд ярихгүйгээр хүний эрүүл мэнд ярих боломжгүй. Яагаад гэвэл мах, сүү, тараг юу байдаг юм бүх тэжээллэг бодистой. Газар хөрсний эрүүл мэнд байхгүйгээр амьтны эрүүл мэндийг ярих боломжгүй. Нөгөө пестицид, хербицид юу байдаг юм бүх энэ бодисууд. Жишээлбэл зүгээр л ингээд хувь хүн дээр аваад үзэхэд л тэгдэг шүү дээ. Мал, мах аваад идье гэхээр зэрэг хамаагүй тариа хийж байна, томруулж байна, таргалуулж байна. Эсвэл сүү, сүүн бүтээгдэхүүн дээр дааврын бодис их хэрэглэж байна. Яагаад гэхээр хүнсний бүтээлийг эрүүл мэндээс хүнс технологийн компаниудаас ялган салгах ямар ч боломж байдаггүй. Тэгэхлээр энэ дээр татаас өгөхдөө ч юм уу эсвэл энэ хүнсний компаниудын энэ том том байгууллагуудын conflict of interest буюу ашиг сонирхлын зөрчлийг энэ хуулиар яаж хааж өгч байгаа вэ. Яаж бусад нийтийн эрүүл мэнд, ялангуяа хүүхдийн сургууль, цэцэрлэгийн эрүүл мэндийг бодлогын түвшинд энд харж үзэж байгаа вэ гэдэг дээр товчхон бөгөөд тодорхой хариулт авъя.

Д.Амарбаясгалан: Мэндбаярын Мандхай гишүүн хариулт өгье.

М.Мандхай: Ганмаа гишүүн ээ, энэ Хөдөө аж ахуйн тухай хууль ярьж байгаа. Хүнсний тухай хууль болохоор энэ Хүнсний тухай хууль дээр илүү нарийн яг таны асуусан асуултууд орох байх. Энэ бид нар Хөдөө аж ахуйн анхдагч хуулийн төсөл мал аж ахуй, газар тариалан, яг энэ салбарын гол бодлогыг тусгах асуудлуудыг илүү энэ хуулиар бол оруулж өгсөн байгаа. Гэхдээ мэдээж хүнсээ бэлдэхэд хөдөө аж ахуйн салбар өөрөө суурь учраас бид нар хүнсний аюулгүй байдалтай холбоотой тодорхой заалтуудыг энэ хөдөө аж ахуй үйлдвэрлэлийг сайжруулах тал дээр бол оруулсан.

Ерөнхий зарчмын хувьд бол хөдөө аж ахуйн үйлдвэрлэл боловсруулах шатад аюулгүй чанартай хүнс үйлдвэрлэхийг бол мэдээж үндсэн зарчмаа болгож оруулсан. Таны түрүүний хэлсэн One health буюу нэг эрүүл мэнд зарчмыг бол бас баримталж, мал ургамал энэ хүрээлэн буй орчны эрүүл мэндийг бид нар яаж илүү хүнсний аюулгүй байдалтай холбох вэ гэдэг асуудал орж байгаа. Тэгээд эргээд нөгөө хөдөө аж ахуйн салбараас гарч үйлдвэрлэгдэж байгаа мал аж ахуй, ургамлын эрүүл мэндтэй холбоотой асуудал дээр мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх хяналтын тогтолцоо, вакцинжуулалт, ариун цэврийн дэглэмийг илүү хуульчлах, тэгээд хүнсний аюулгүй байдлын анхан шатын баталгаа болгож байгаа анхан шатын зохистой дадлыг анхан шатын өртгийн сүлжээн дээр зохистой дадлыг нэвтрүүлсэн байх, дээрээс нь техникийн зохицуулалт стандартуудыг дагаж мөрддөг байх шаардлагыг энэ хуулиар зохицуулж өгсөн. Тэгэхээр Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл тодорхой хэмжээний үйлдвэрлэл эрхлээд

борлуулж худалдан авч л байгаа нөхцөлд эдгээр стандартуудыг бол зайлшгүй нэвтрүүлсэн байх ёстой. Ер нь манай хөдөө аж ахуйн салбарт бол хүнс болон мал аж ахуйн өөрийн гэсэн MNS стандартууд бол хэрэгжиж явж байгаа. Тэгэхээр энэ стандартууд, техникийн зохицуулалтуудыг бол үйлдвэрлэл болгон дээрээ, өртгийн сүлжээ болгон дээр хэрэгжүүлээд явах ийм шаардлага хэрэгцээтэй байгаа.

Боловсруулах үйлдвэрлэл дээр мэдээж мал, ургамлын гаралтай түүхий эдийг боловсруулах явцад илүү нөгөө эрүүл ахуйн стандартыг мөрдөх, лабораторийн тэр шинжилгээ бол зайлшгүй хийх ийм заалтууд бол байгаа. Нэмүү өртгийн сүлжээнд бол мэдээж гарал үүслийн баталгаат байдлыг илүү цахимаар бүртгэдэг болох, энэ хууль дээр бид нар мэдээллийн сан гэдэг бол өөрөө энд тэнд зөрүүтэй мэдээллийн сангаас болоод эргээд энэ нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд төвөг учирдаг, дээрээс нь экспортод гарах гэж байгаа худалдан авагч тал өөрөө мэдээлэл ойлгомжгүй зөрүүтэйгээс болоод энэ салбарын хөгжилд чөдөр тушаа болдог учраас бид бид нар илүү блокчэйн дээр суурилсан мэдээллийн сантай байх, бүх түвшинд нь нөгөө мөрдөн мөшгөх буюу traceability мөшгөх тогтолцоо дээр хүртэл энийг асуудлыг зохицуулах ёстой юм байна гэдгийг энэ хуулиар бас оруулж өгсөн байгаа.../минут дуусав/

Х.Булгантуяа: Нэмж тодруулъя Ганмаа гишүүн.

Д.Ганмаа: Эхлээд асуултдаа бүрэн хариулт авчихъя. Хариулт дуусаагүй учраас тэндээс бодвол хариулах байх.

Х.Булгантуяа: Мандхай гишүүн нэмж хариулъя.

М.Мандхай: Тэгээд яах вэ, энэ төсөл өөрөө нөгөө Хүнсний тухай хуулийг орлохгүй ч гэсэн хөдөө аж ахуйн нөгөө үйлдвэрлэлийн эхлэхээс нь эхлээд анхан шатаас нь эхлээд нөгөө зах зээл хүртэлх хүнсний аюулгүй байдлыг бол дэмжих ийм нэмэлт хамгаалалт болж байгаа хууль гэж бас хэлэх нь зүйтэй байх, илүү нөгөө эрүүл мэнд зарчмыг нэвтрүүлэх, түрүүн миний хэлсэн лабораторийн хяналтын тогтолцоог хуульчлах, гарал үүсэл, ул мөрийн бүртгэлийг илүү цахимжуулах ийм зохицуулалтууд бол энэ хуулиараа орсон байгаа гэдгийг хэлмээр байна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Ганмаа нэмж тодруулна.

Д.Ганмаа: Энэ хүнсний тухай хуульдаа саяын нэрлэсэн энэ хуулийн хэрэгжилтүүд маш муу байгаад байна шүү дээ. 2012 оноос эхлээд л явсан. Тэгээд 27%-тай, 40%-тай. Тэгэхээр энэ дээр яг дэмнэсэн тусалсан, хөдөө аж ахуйг яг one health зарчмаар энэ хуулийг том малгай болгож, суурь хууль болгож хэрэгжүүлж байгаа юм бол яаж дэмнэсэн юм бэ. Ямар зүйл, заалтыг нь өөрчилсөн юм бэ. Зарчмын бодлогын түвшинд энэ чинь яаж өөрчлөгдөх юм бэ. Эрүүл мэнд, одоо ярьж байна шүү дээ жишээлбэл, сургуулийн юм уу, цэцэрлэгийн хүүхдийн энэ юу чинь бодлого хэмжээнд нь яаж дэмжиг байгаа юм бэ. Бүр тухайлбал хүнсний баяжуулалтын хуультайгаа энийгээ яаж уялдуулж өгч байгаа юм бэ гэдэг асуултад л хариулт авмаар байх юм.

Х.Булгантуяа: Мандхай гишүүн нэмж хариулъя.

М.Мандхай: Ганмаа гишүүний асуултад хариулъя. 1 дүгээрт Хөдөө аж ахуйн хууль бол өөрөө анхдагч хууль байгаа. Хүнсний тухай хууль бол 13 жилийн дараа

нэмэлт, өөрчлөлт хийгдээд, хуулийн төсөл бол өргөн бариад, энэ 5 дахийн чуулганаар хэлэлцүүлэгдэхээр хуваарьт орсон байгаа. Тэгэхээр би Хүнсний тухай хуультай холбоотой яг нарийн зохицуулалттай асуултыг тэр үед Хүнсний тухай хууль хэлэлцэх үед хариулах нь зөв байх. Гэхдээ би түрүүн хэлсэн. Хөдөө аж ахуйн хууль бол мэдээж гол нь нөгөө хүнс үйлдвэрлэх бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байгаа хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эхлэлээс зах зээл дээр хүртэлх хүнсний аюулгүй байдлыг дэмжих нэмэлт өөрөө хамгаалалт болж өгч байгаа. Тэгээд түрүүн хэлсэн 6 ерөнхийдөө асуудал бол энэ хуулийн хүрээнд орсон байгаа. Гол нь энэ нөгөө ерөнхий зарчмын асуудал байна. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн. Мал аж ахуй, ургамлын.../минут дуусав/

Х.Булгантуяа: Мандхай гишүүн гүйцээж хариулъя..

М.Мандхай: Нөгөө мал аж ахуй, ургамлын эрүүл мэндийн энэ урьдчилан сэргийлэлт, хяналтын тогтолцооны асуудал байгаа. Мэдээж вакцинжуулалт ариун цэвэр хангах, хүнсний аюулгүй байдлын тэр анхан шатын баталгаа болж байгаа асуудлыг энэ хуулиар тусгаж өгсөн. Боловсруулах үйлдвэрлэлтэй холбоотой бас зохицуулалт, хяналт шинжилгээ, үнэлгээ буюу энэ үүн дээр Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлын лабораторийн хяналт тогтолцоог бол хуульчилж өгсөн байгаа. Тэгээд мөн импорт, экспортын зохицуулалт, гадаад худалдаанд орж байгаа жишээлбэл хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлын шаардлага тавьж, эрсдэлийн үнэлгээ хийх ийм журам, импортын орлого, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих замаар хүнсний баталгаат байдлыг хангах ийм зорилго, дээрээс нь 6-д нь хоршоо, кластер, нэгдэл, нийлүүлэлтийн сүлжээг бид нар бас хөгжүүлж өгөх шаардлагатай. Энэ дээр чанар гарал үүслийн хяналтын тогтолцоог бол илүү энэ хууль дээрээ бас тусгаж өгсөн байгаа.../минут дуусав/.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар.

Н.Наранбаатар: Гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр би бол яг үнэндээ энэ хуулийг уншиж үзээд яг юуг зохицуулах гээд ийм хууль тусад нь гаргах гээд байгаа юм бол гэж жаахан гайхаад л уншаад суугаад байгаа юм. Засгийн газраас өгсөн саналыг харсан. 6 хуультай зөрчсөн байна гэж. Засгийн газрын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль гээд зөрчилдсөн гэсэн санал байх юм. Сайд байж байна. Би бодлогын яамнаас нь бас тодруулъя. Энэ юуг шийдэх гээд байгаа хууль юм бол. Яамны бодлого яамны санал юу байгаа юм бол гэсэн.

Хуулийн төслийг харвал архивтай байна, лабораторитой байна, цахим сантай байна гээд яамны хийх ажлууд заавал хуульчлаад байх шаардлагагүй ажлууд. Тэртээ, тэргүй орон нутаг бол дутагдалтай мэргэжилтнүүдээ ингээд жил бүхэн судалгааг нь гаргаад, бэлдээд л явдаг. Тэгээд энэ хууль дээр орон нутаг хөдөө аж ахуйн боловсон хүчний сургалтын төлбөрийг даана. Ажлын байраар хангана гэж хууль дээр бол зааж болохгүй. Орон нутгийн төсөв гэдэг чинь энэ Их Хурлаас Их Хурлын гишүүд шийдээд байдаг асуудал биш л дээ. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага нь төсвөө өөрөө батлах, захирч зарцуулах ийм Үндсэн хууль, нэгжийн хуулиар халдашгүй эрхтэй л дээ. Тэгээд иргэдийн Хуралд нь төсвөө ийм юманд зарцуул, тэг ингэ гэх салбарын хуулиар бол зохимжгүй. Хууль, эрх зүйн хувьд зөрчилтэй.

Мөн сургалт хариуцсан байгууллага, менежертэй байна, лабораторитой байна, лаборатори хариуцсан боловсон хүчинтэй байна гээд л заагаад байгаа юм. Энэ нь тэгээд манай хэмнэлтийн хуультай, сая бид чинь төрийн албан хаагчдыг 9%-аар цомхотголоо. Төрийг нөгөө данхар байна гээд манай засгийн бодлого чинь энэ төрийг цомхон болгоно уу гэхээс дахиж бүтэц, орон тоо нэмнэ гэж байхгүй байгаа шүү дээ. Бидний бодлоготой хууль маань хэр нийцэж байгаа юм бол гэсэн иймэрхүү асуултууд байх юм.

Тэгээд тэртээ тэргүй Малчны тухай хууль гээд байгаа. Тариалангийн тухай хууль байгаа. Хүнсний аюулгүй байдлын тухай хууль байгаа. Ургамлын, малын генетик нөөцийн хууль байгаа. Ингээд маш олон хуулиудаар энэ Хөдөө аж ахуйн харилцааг зохицуулсан байдаг юм. Тэгэхээр бүгдийг нь ингээд нэг малгай доор, дээвэр доор авчраад Хөдөө аж ахуйн тухай хууль гээд тавихаар нөгөө хууль хоорондын давхардал гэдэг юм бий болохгүй юу гэдэг нэг ийм хэдэн асуултуудад хариулт авъя. Эхлээд яамнаас хариулт сонсоодохъё. Тэгээд дараа нь ажлын хэсгийн хариултыг сонсьё.

Х.Булгантуяа: Эхлээд хууль санаачлагч Мандхай гишүүн хариулчих. Тэгээд нэмээд ажлын хэсгээс хариулаарай. Мандхай гишүүний микрофон.

М.Мандхай: Наранбаатар гишүүнд баярлалаа. Тэгээд яах вэ, энэ нөгөө хуулийн бас нарийн нөгөө нюанстай холбоотой мэдээллүүдийг бас тайлбарлаж өгөх нь зүйтэй гэж бодож байна. Тэгээд энэ хуулиар төрөөс хөдөө аж ахуйг хөгжүүлэх бодлогын зарчмыг тодорхойлж байгаа. Бид нар ер нь бол нийт 30 орчим хууль түрүүн хэлсэн. Салбар хуулиуд бол байгаа. Тэгээд салбар хуулиуд байсан ч гэсэн эцсийн үр дүнд ер нь энэ бодлого өөрөө яг ямар зарчимтай явах вэ гэдэг 1 дүгээрт, 2 дугаарт өртгийн сүлжээ өөрөө яаж илүү тогтвортой үйлдвэрлэл эрхлэх вэ гэдэг энэ гол хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн төрөлжилт, энэ нэгдмэл цогц байдлыг л хангах ийм шаардлага хэрэгцээ практик дээр үүсээд байгаа юм.

2 дугаарт хуулийн хувьд ч гэсэн салбар хуулиуд маань өөр өөрсдөө салбар хөгжөөд яваад байдаг. Гэтэл энэ Хөдөө аж ахуйн салбарын хувьд бодлого яаж нэгдмэл 1 ийм интеграцтай явах вэ гэдэг асуудал бас мөн адилхан практик дээр үүсээд байгаа учраас энэ тогтвортой хөгжлийг дэмжих зорилготойгоор энэ малгайн хуулийг гаргаж ирэх ийм шаардлага хэрэгцээ үүссэн гэдэг нь судалгаагаар гарсан байгаа юм. Тэгээд ер нь бол 1 дүгээрт энэ бодлогын зарчмуудыг тодорхой болгож байгаа. 7 дугаар зүйл дээр хөдөө аж ахуйг төрөлжүүлэх, хөгжүүлэх асуудлуудыг нэлээн дэлгэрэнгүй кластер, захиалгат бүтээгдэхүүн, хоршоо, ер нь энэ хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн төрөлжилт юу юу байх вэ. Яаж бид нар хөгжих юм бэ гэдэг асуудлуудыг илүү дэлгэрэнгүй тусгаж оруулж өгсөн.

Хуулийн хувьд хөгжлийн бодлого, түүний удирдлагын тухай хуультай ямар ч зөрчилдсөн асуудал бол байхгүй. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоо нь өөрөө улсын түвшинд үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, салбарын түвшинд, төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, орон нутгийн түвшинд болохоор аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгж, сумын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан ажилтнаас бүрдэнэ гээд үндсэндээ салбарын түвшинд бол салбарын зорилтот бодлогоо сайн тодорхойлж, боловсруулаад Улсын Их Хурлаар батлуулж хэрэгжүүлэхээр бол заасан байгаа. Тэгэхээр энэ дээр ямар нэгэн зөрчилдөх асуудал байхгүй.

Үндсэн чиглэл Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт бол туссан. Боловсруулахаар бол заасан байгаа. Янз бүрийн гол нь энэ бодлого дээр янз бүр гардаг байгаа учраас энэ ерөнхий зарчмаа л бид нар тодорхойлж өгсөн ийм хууль болсон гэж хэлж болно.

Мөн таны асуусан асуулт дээр салбарын онцлог ер нь бол энэ хариуцлагыг нэмэгдүүлэх дээр хуульд зааснаар малын тоо толгойн албан татвар гээд түрүүн бас Уянга гишүүн дурдсан. Бусад орон нутгийн татвар, төлбөрөөс бүрдэх энэ орлогыг илүү хөдөө аж ахуйг дэмжих, байгаль орчныг хамгаалахад бас..../минут дуусав/

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн микрофон. 4 номероос яамнаас нэмж хариулъя. Яамны байр суурь ямар байгаа вэ гэж. Ж.Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Улсын Их Хурлын гишүүд бүрэн эрхийнхээ хугацаанд Хөдөө аж ахуйн анхдагч хуулийг өргөн барьсан байна. Салбарын сайдын хувьд салбараас өгсөн санал хуулийн төсөлд тусаагүй. Ажлын хэсэгт салбарын яамны төлөөлөл оролцоогүй. Хууль боловсруулахад. Энийг хэлэх нь зүйтэй. Нэгэнт хууль боловсрогдоод өргөн барьсан нөхцөлд хуулийг боловсронгуй болгох чиглэл дээр Хөдөө аж ахуйн яан хамтран ажиллана. Олон асуудлууд байна. Жишээлбэл өнөөдөр яг Хөдөө аж ахуйн маань уул уурхайгаас хэт хамааралтай Монгол Улсын эдийн засгийг олон тулгуурт болгоход гол шийдвэрлэх салбар мөн үү мөн. Иймд бид нар бүтэц зохион байгуулалтын нэгдмэл байдлаас авхуулаад хүний нөөц, боловсон хүчин бэлтгэж байгаа тогтолцоо, хөдөө аж ахуйн шинжлэх ухаан, судалгаа, хүрээлэнгийн тогтолцоо, салбарыг хөгжүүлэх бодлогуудаа 1 мөр сайн цогц ярих зайлшгүй шаардлага байгаа юм. Тэгэхээр энэ хуулиар тийм бололцоо үүсэх байх. Нөгөө талаар .../минут дуусав/

Х.Булгантуяа: Энхбаяр сайдын микрофоныг нэмж өгье.

Ж.Энхбаяр: Боловсронгуй болгох олон зүйл харагдаад байна л даа. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, өртгийн сүлжээ гэхэд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн ангилал төрөл нь их явцуу тодорхойлчихсон байгаа юм. Зөвхөн мал аж ахуй, газар тариалан, хадлан тэжээл, хөдөө аж ахуй, агро, ойн аж ахуй гэсэн маягаар. Гэтэл энэ маань хөдөө аж ахуйн усжуулалт, хүнсний үйлдвэрлэл, хөнгөн үйлдвэрлэлүүд, тэгээд гахай, тахиа, загасны аж ахуйнууд, эм био бэлдмэлийн үйлдвэрлэл, ургамал хамгааллын бодисын үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн техникийн үйлдвэрлэл гээд хүрээ маш өргөн байгаа. Ингээд ийм өргөтгөх сайжруулах зүйлүүд их харагдаад байна. Тэгэхээр гүйцээн боловсруулаад, ажлын хэсэг Байнгын хороо дээр гаргах байх. Энд яамны төлөөлөл, мэргэжлийн хүмүүсийг их өргөн оролцуулахыг хүсэж байна.

Х.Булгантуяа: Наранбаатар гишүүн нэмж тодруулъя.

Н.Наранбаатар: Тэгэхээр хууль дээрээ эргэж маш сайн ажиллах хэрэгтэй юм байна гэж. Хэрвээ хэлэлцэх эсэх нь дэмжигдээд явбал мэдээж ажлын хэсэг байгуулагдах байх. Маш их зүйлүүд дээр эргэж судлах хэрэгтэй байна. Хэлэлцүүлгүүдийг сайн хийх хэрэгтэй байна. Орон нутаг, ялангуяа орон нутгаар, малчдын дунд тэр газар тариалан эрхлэгчид, хүнсчдийн дунд гээд маш өргөн хэмжээний хэлэлцүүлгүүдийг урт хугацааны туршид нэлээн цаг хугацаа авч нэгмөсөн сайн хууль гаргах ёстой. Бусад хуулиудтай давхардал байхгүй, хийдэл байхгүй ийм байдлаар. Тэгээд яамны санал Засгийн саналууд нэгдсэн байх ёстой. Тэгэхгүй яг өнөөдөр энэ хуулийн төслийг харахад бол тодорхой юу шийдэх гэж

байгаа нь мэдэгдэхгүй, бусад хуулиудтайгаа давхацсан, тооцоо судалгаа муутай, яамтайгаа, засагтайгаа нэгдсэн ойлголцолд хүрээгүй хууль батлах юм бол цаашаа хэрэгжилт бол тааруу байна шүү л гэж хэлье.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Мандхай.

М.Мандхай: Тэгэлгүй яах вэ, Наранбаатар гишүүний хэлж байгаа шүүмж, саналыг бол хүлээж авна. Хэлэлцэх эсэх асуудал шийдэгдээд явсны дараа Байнгын хороо дээр ажлын хэсэг байгуулагдахаар нэлээн өргөн хүрээнд орон нутгийн түвшинд ч гэсэн хэлэлцүүлэг хийгээд илүү саналыг бол тусгаад явна. Гэхдээ яах вэ, энэ хууль дээр бол түрүүн бас хэлж байна лээ. Үйлдвэрлэлийн ангилал төрөл хангалттай ороогүй байна гэсэн. Ер нь бол манай энэ Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг төрөлжүүлэх дээр бол гахай, шувуу бусад төрлийн хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, хүнс үйлдвэрлэл бол бүгд тусгагдсан байгааг бас онцлох нь зүйтэй гэж бас хэлмээр байна. Тэгээд хамгийн гол нь бид нар энэ хуулийн гол зориулалт нь өөрөө түрүүн хэлсэн. 1 дүгээрт энэ олон салбар хуулиудын зохицуулах шаардлагатай буюу малгай хууль хоорондоо интеграцитай уялдаа холбоотой явах асуудал хөндөгдөж байгаа учраас .../минут дуусав/

Х.Булгантуяа: Мандхай гишүүн гүйцээж хариулъя.

М.Мандхай: Салбар, дэд салбар хуулиуд маань илүү технологийн болон процессын шинжтэй хуулиуд байгаа. Хөдөө аж ахуйн өөрөө бодлогын том малгай яаж хөдөө аж ахуйн бодлого өөрөө хэрэгжиж ямар зарчимтай явах вэ, өртгийн сүлжээ тус бүрд нь юуг хамааруулах юм. Энэ дээр гол нь энэ хөдөө аж ахуйн салбараар үйлдвэрлэгдэж гарч байгаа бүтээгдэхүүн өөрөө чанар аюулгүй байдалтай байх зохицуулалт өөрөө малгай хуульдаа зайлшгүй хуульчилж орохгүй бол журмаар зохицуулагдаж явсан нөгөө практик туршлага маань эргээд Хөдөө аж ахуйн салбар, өнөөдөр төрөөс өгч байгаа дэмжлэг олон хуулиуд байгаа боловч яагаад энэ Хөдөө аж ахуйн салбар хөгждөггүй, ДНБ-ий 3,6 хувьд л ингээд байгаад байдаг. Хүн амын 26 орчим хувь нь энэ салбарт ажиллаад байдаг. Ингээд энэ салбар яагаад өндийдөггүй юм бэ гэдэг асуудал тулгамдаж байгаа учраас Хөдөө аж ахуйн малгайн хуулийг бол гаргаж ирснээрээ .../минут дуусав/

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Банзрагчийн Түвшин.

Б.Түвшин: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Хөдөө аж ахуйн тухай хууль бол яалт ч үгүй маш чухал хууль. Тэгээд энэ хуулийг нэгэнт барьж авсан бол нэлээн томоохон асуудлыг цогцоор нь шийдэх ёстой гэж үзэж байгаа. Өнөөдөр бид нар хөдөө аж ахуйн орон. Тэр дотроо нүүдлийн мал аж ахуйн орон. Нүүдлийн мал аж ахуй бол Монголчуудын өрх гэрээрээ үйлдвэрлэдэг, Монголчуудыг үйлдвэрлэгч гэдгийг харуулдаг ийм нэг талдаа соёл, нөгөө талдаа бид нар яг юу хийж амьдардаг вэ гэсэн үг. Гэтэл малчид маань улам багасаад байдаг. Яагаад багасаад байгаа шалтгаан дээр нь биш, бид нар шаардлага дээр нь ажиллаад байдаг. Үнэхээр энэ малчид бол бизнесээ хийж байгаа. Биологийн үйлдвэрлэл эрхэлж байгаа. 10 хонийг 20 болгож байна. 20 хонийг 40 болгож байна. Гэтэл энэ дээр чинь бид нарын бүх бодлого яг энэ малчдыг дэмжихгүй байхын төлөө явж байгаа юм шиг харагдаж байгаа. Дээлээ даадгийг нь сургууль аваад явчихна. Дээврээ даадгийг нь цэрэгт аваад явчихна. 2 хүн үлдчихнэ. 20 өнөө хотод авчраад борлуулъя гэхлээр тээврийн зардалдаа хүрдэггүй.

Улаанбаатарынхан бас гомдолтой. Дотоодын үйлдвэрийн аргаар боловсруулсан мах хаяа дэлгүүрээсээ авах боломжгүй. Хаана ч олдохгүй. 1 бол фермерийн асар өндөр үнэтэй махнууд байж байдаг. 1 бол хагас боловсруулсан зах дээрээс олж авдаг. Энэ хоорондын логистикоо хийж, малчин хүнийг тэр биологийн үйлдвэрлэл эрхэлж байгаа хүнийг бараа бүтээгдэхүүнээ чөлөөтэй зардаг энэ үндсэн логистикийг нь бид нар босгох ёстой. Ингэж байж дараа нь эрүүл байх асуудал, ингэж байж дараа нь тоо толгойгоо барих асуудал, ингэж байж дараа нь тэр малчдыг орлоготой болгосны дараа тэжээдэг болгох, үүлдэр угсаагаа сайжруулах, эрүүл ахуйн асуудлууд яригдана шүү дээ. Эхлээд шаардлагууд нь явчихдаг. Малаа зарах логистикийн тогтолцоо байхгүй. Тэгвэл энэ дотоодын үйлдвэрийн аргаар боловсруулсан, ялангуяа махан дээр суурилсан энэ үндсэн тогтолцоог суурилж байж энэ үндсэн тогтолцооны дараа дагавар, дайвар бүтээгдэхүүнүүд нь тасралтгүй үйлдвэрлэгдэн гарч байж, энэ ЖДҮ-үүд хөгжих боломжтой.

Тэгэхээр бодлого маань малчдыг халамж өгөх гэдэг талаасаа биш. Малчдыг яаж байнгын орлоготой болгох вэ, малчдыг яаж бизнесмен болгох вэ, энэ Улаанбаатар хотынхныг яаж боловсруулсан дотоодын махаар тасралтгүй хангах вэ, улирлын шинж чанараас нь яаж гаргах вэ, яаж энэ худалдан авалтын тогтолцоог хийх вэ гэж байгаа юм. Өртгийн сүлжээ гэж яриад байх юм. Value chain үнэ цэний сүлжээг бид нар хийх ёстой. Энэ сүлжээ болгон үнэ цэнтэй байж байж малчид байнгын орлоготой болно. Ингэж байж малчид ялангуяа одоо мянгат малчин гэж нэрлэх мянган малтай хүнийг хэлдэг биш, мянган мал зардаг хүнийг хэлнэ. Энэ үндэсний тогтолцоог яаж хийх вэ, яаж төлөвлөж байна. Энэ үндэсний тогтолцоог яаж бий болгох вэ. Экспортод мах экспортолъё л гээд л хэдүүлээ яриад байдаг. Яг одоо энэ ченжийн тогтолцоогоор ченжийн ч үр ашиггүй, малчдад ямар ч хэдэн ч толгой мал гадаадад гаргасан үр өгөөж нь хүртэхгүй хямдхан үнээр тууварлаж аваад л хэн нэгний үйлдвэр дээр боловсруулаад л гаргачхаж байна. Үндэсний дотоодын энэ сүлжээг бий болгоод, энэ тогтолцоогоо үнэ цэнтэй болгож байж дараа нь бид нар экспортын асуудал ярина. Ингэж байж нүүдлийн мал аж ахуйг нүүдлийн чигээр нь хадгалах, нүүдлийн өв соёлоо хадгалахаас гадна нүүдлийн малчин өөрөө биологийн үйлдвэрлэл эрхэлж байгаа үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээ борлуулдаг зах зээл нь нээгдэж байгаа. Тэгэхээр энэ хууль дээр энэ тогтолцоог яаж оруулсан. Ер нь малчдыгаа цааш нь хөгжүүлэх, бизнесмен болгох, орлоготой болгох, Улаанбаатар хотынхныг энэ дотоодын үйлдвэрийн махаар тасралтгүй орон нутгаас ирсэн тасралтгүй цэгүүдтэй болж, хүнсээрээ хангагдах энэ боломжийг яаж энэ хууль дээр тусгасан бэ гэдэг дээр би асуулт асууя.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Мандхай асуултад хариулъя.

М.Мандхай: Энэ хуулийн ерөнхийдөө 7 дугаар зүйл дээр буюу бас 2 дугаар бүлгийн 6, 7 дугаар хэсэг дээр түрүүн хэлсэн. Яах вэ, ер нь бол нөгөө хөдөө аж ахуйн яг энэ өөрийнх нь албан ёсны тодорхойлолтоор бол жишээлбэл ханган нийлүүлэлтийн сүлжээ бол өөрөө яг өртгийн сүлжээ юм шиг ойлгогдоод, нэмүү өртгийн сүлжээ бол ингээд тусдаа юм шиг мөртөө яг хөдөө аж ахуйн албан ёсны мэргэжлийн хэллэгээр бол өртгийн сүлжээ гэдгээр нь нийтэд нь хамааруулаад, ханган нийлүүлэлтийн сүлжээ болон өртгийн сүлжээ гэж явж байгаа. Тэгээд энэ хууль дээр бол яг өртгийн сүлжээ гээд дараа дараагийнх нь ханган нийлүүлэлтийн сүлжээг тусгаж оруулж өгсөн байгаа.

Тэгээд 2 дугаарт илүү энэ хамгийн чухал таны хэлээд байгаа малчид малаас гарч байгаа бүтээгдэхүүнээ худалдан борлуулах гэхээр дараагийн шатын өртгийн сүлжээ нь худалдаж авах цэг өөрөө тодорхой бус дараагийн худалдаж аваад тэрийг нь тогтвортой хангаж авдаг ийм тогтолцоо байхгүй байгаа учраас энийг ерөөсөө хуульчлахгүй бол болохгүй юм байна гэдэг үүднээс энэ хууль дээр анхан шатын өртгийн сүлжээ тухайн сум дээр түүхий эдийг худалдаж авах төвлөрсөн цэгийг бий болгоё. Одоогийн байдлаар бол ченжүүд бол авч байгаа. Тэгэхээр илүү ченж ч гэсэн илүү боловсронгуй түвшинд ажиллах нь зүйтэй юм байна. Тэгээд төвлөрсөн цэгээсээ түүхий эдээ худалдаж аваад, дараагийн шат дамжлага буюу логистик тээвэрлэлтээ хийгээд, дараагийн өртгийн сүлжээнд нийлүүлдэг энэ тогтолцоог бий болгоё. Энэ дээр нь бас чухал асуудал орсон. Энийг нь тогтвортой нийлүүлэх дэмжих дэмжлэг нь өөрөө хөдөө аж ахуйн дэм. Хөдөө аж ахуйн дэмжлэг бол ингээд л тасралтгүй урамшуулал өгөөд байдаг тухайн салбар өөрөө яг босож ирдэггүй. Эрсдэл бий болоход дахиад л нэмж урамшуулал бол өгөх үү гэдэг асуудал өнөөдрийн байдалд тулгамдчихаад байгаа шүү дээ. Тийм учраас бид эднийг ерөөсөө энэ өөрөө чанар стандартад нийцсэн тогтвортой нийлүүлэлтийг хөгжүүлээд явах юм бол төр нь өөрөө тэрийгээ илүү дэмждэг байя. Ингээд дотоодын үйлдвэрлэлүүдийг илүү хөгжүүлж хамгаалахад зориулсан ийм зохицуулалт зайлшгүй шаардлагатай байгаа учраас энэ хуулийг оруулж өгсөн байгаа.

Тэгээд хөдөө аж ахуйн бас яг үйлдвэрлэлийн ангилал төрөл дээр бид нар зөвхөн мал аж ахуй, тариалан гээд хязгаарлахгүйгээр илүү өргөн цар хүрээнд хадлан тэжээл үйлдвэрлэлээр байж болно. Агро аж ахуй, хөдөө аж ахуйн аялал жуулчлал, тэр байтугай малчин дээр очоод фермер юм уу, газар тариалангийн чиглэлийн аялал жуулчлалыг хүртэл хөгжүүлэх төрөл ангиллыг нь хүртэл бид нар энэ хуульдаа нарийвчилж тусгаж өгсөн байгаа.

Аж ахуй үйлдвэрлэлийн хувьд бол малчид маань тариаланчид маань илүү олон төрлөөр хослон бас үйлдвэрлэл явуулах төрөлжин хөгжүүлэхийг оруулж өгсөн гэдгийг бас хэлмээр байна. Тэгээд манай ажлын хэсгээс .../минут дуусав/

Х.Булгантуяа: Түвшин гишүүн нэмж тодруулъя.

Б.Түвшин: Ер нь бол бид нарт хууль ихдээгүй шүү дээ. Тэгээд хууль ярихаараа дандаа чанар, стандарт, шаардлага гээд ингээд яваад байдаг. Гэтэл энэ тогтолцоо чинь нураад уначихсан. Зах зээлтэйгээ холбогдохгүй байгаа. Улаанбаатар хотод яг дотоодын аргаар боловсруулсан дэлгүүрүүд нээгдэх юм уу, нээгдэхгүй юм уу. Энэ чанар стандартыг нь дотооддоо тааруулсан болгож хөгжүүлэх юм уу, үгүй юм уу. Дагавар, дайвар бүтээгдэхүүн бол үндсэн шугамынхаа дараа үүснэ шүү. Хониныхоо цөсийг үнэ цэнтэй байлаа гээд малчид хонио гаргадаггүй байхгүй юу. Үндсэн махаа, мал аж ахуй чиглэлээ үндсэн шугамаа гаргаж ирж байж, дараа нь дагавар, дайврууд гарч ирнэ. Тэгэхээр юу хэлэх гээд байна вэ гэхээрээ яг энэ үндсэн Value chain буюу тогтолцоогоо зөв гаргаж байж энийг дэмжих бодлогын эрх зүйг энэ хуулиар гаргаж өгч байж энэ хууль цаашаа явах болов уу. Түүнээс биш чанар, стандарт, шаардлага гээд борлогдохгүй байгаа мал дээр эрүүл ахуйн шаардлага, борлогдохгүй байгаа мал дээр бүтээмжийн асуудал, борлогдохгүй байгаа малын тоо толгойг/минут дуусав/

Х.Булгантуяа: Мандхай гишүүн хариулах уу. Мандхай гишүүн.

М.Мандхай: Тэгэхээр Түвшин гишүүнтэй бол санал нэг байна. Тэгээд энэ хэлэлцэх эсэх асуудал дэмжигдээд явахаар илүү бүр энэ хууль дээр нарийвчилж оруулах, тусгах шаардлагатай бас зүй зүйл, заалтуудыг хэлэлцүүлгийн үеэр бас нэмээд оруулъя гэж бодож байна. Тэгээд 12.1 дээр бол илүү тогтвортой хөдөө аж ахуйг хөгжүүлэх зорилгоор улсын хэмжээнд дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөртэй байя гэдгийг бас тусгаж оруулсан байгаа. Энэ зорилтот хөтөлбөрийг болохоор илүү хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 12.1-д заасан зорилтот хөтөлбөрийг Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохицуулна. Тэгээд таны түрүүн хэлсэн орон нутгуудад өгч байгаа дэмжлэг сан бол энэ өөрөө орон нутгийн бас яг адилхан хөдөө аж ахуйг хөгжүүлэх хөгжлийн зорилтот хөтөлбөртэй уялдсан санхүүжилтийг бас төсөвлөдөг, төсвийг төсөвлөдөг байх. Эргээд энийг нөгөө таны хэлж байгаа анхан шатын .../минут дуусав/

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж дууслаа. 2 гишүүн үг хэлэхээр нэрээ ирүүлсэн байна. Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэболд 2 дугаар индэр дээрээс. Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд.

С.Эрдэнэболд: Мандхай гишүүн болон Улсын Их Хурлын зарим гишүүдийн санаачилсан хуулийг үзэл баримтлалын хувьд дэмжиж байгаа. Тэгээд хэдэн зүйл дээр бас саналаа хэлэх гэж байгаа юм.

1 дүгээрт нь болохоор 2010 онд бид нар үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг баталсан. Тэр үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын үйлчлэлийг харахаар ер нь 2020 он хүртэл зарим зүйл заалтууд нь бас зориулагдсан харагдаад байгаа юм. Жишээлбэл, эрчим хүчний бодлого ч гэдэг юм уу, шатахууны бодлого ч гэдэг юм уу. Ингээд аваад үзэхээр үндсэн 6 тулгуур зарчим байгаа. Үүний 1 нь энэ үндэсний аюулгүй байдалтай холбоотой сэдэв нь яг энэ хүнс, хөдөө аж ахуйн салбартай холбоотой асуудал байгаа юм. 2021 онд шинэ Ерөнхийлөгч гарч ирээд, 2022 онд яг энэ үзэл баримтлалын ажил дахиад шинэчлэгдэх процесс явж байгаад, одоо зогсчихсон байгаа. Тэгэхээр одоо юу гэж хэлэх гэж байна гэхээрээ бид нар 10 орчим дунд болон урт хугацааны бодлогын бичиг баримтад эдгээр бодлогуудыг энэ хуулиудыг нийцүүлэх зайлшгүй шаардлага байгаад байгаа юм. Тэгэхээр яг энэ үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал тэр дотроо яг хүнс, хөдөө аж ахуйтай холбоотой асуудлуудтай үүнийг уялдуулах зайлшгүй шаардлага гараад байгаа юм. Тийм учраас энэ чиглэлийн судлаачидтай бас уулзаж энэ чиглэлийн бас мэдээлэлтэй уялдуулах байдлаар энэ хуулийг хэлэлцүүлгийн явцын дунд бас ажиллаасай гэж бодож байгаа юм. 1 дүгээр санаа.

2 дугаар санаа болохоороо энэ импортын хүнсний асуудал. Нэгэнт энэ бол хүнсний хууль учраас бүгдийг багтаах албагүй ч гэсэн хамгийн чухлуудыг багтаах зайлшгүй шаардлагатай байгаад байгаа юм. Сүүлийн үед өнгөрсөн 2 сарын 3, 4-ний үед утааны асуудлаар сонсгол хийхэд энэ эрүүл мэндийн асуудлыг ярьж байхад зарим хүмүүс бас хорт хавдрын асуудлыг хүнстэй холбож маш их судлаачид ярьж байсан. Монголчуудын амьдралын хэв маяг, идэж ууж байгаа зүйл, тэр тусмаа импортын бараа бүтээгдэхүүн орж ирж байгаа, тэр дээр тавих хяналт, тэр нь эрүүл мэнд гений өөрчлөлтөд орж байна уу, орохгүй байна уу, тостой холбоотой асуудал гээд. Тэгээд энэ бүх зүйлүүд бас яг энэ аюулгүй байдалтай холбоотой сэдэв. Хүнстэй шууд холбогдож байгаа. Энэ зохицуулалтыг нэлээн өргөн хүрээгээр оруулах шаардлагатай байгаад байна.

3 дугаарт мал аж ахуйн сая энэ Банзрагчийн Түвшин гишүүн их мэргэн шийдлүүд хэлж байна л даа. Тэр био үйлдвэрлэл, дээрээс нь эргэх холбоо, тэгээд мал маллаж байгаа малчдаас яг эцсийн бүтээгдэхүүнийг хэрэглэж байгаа хэрэглэгч, дээрээс нь ургац ногоо тарьж байгаа тариаланч, ногоочдоос эцсийн хэрэглэгч хүртэлх энэ эрүүл тэр Value chain гээд байгаа энэ баялаг бүтээгчдийг яг хэрэглэгчдийн зөв системээр холбосон тэр холболтуудын зохицуулалт нь хэрэгтэй байгаад байгаа. Одоо бол ченж гээд хүмүүс дунд нь нугалчихдаг. Малчид бол тэр болгон ашигтай биш, дунд нь ченж хожлоо гэдэг юм яригдаад байгаа тийм үү. Энэ дотроо нөгөө жишээлбэл cold chain гэдэг хөргүүрийн тогтолцоо, тэр стандарт нь ямар байх юм. Одоо жишээлбэл, Батнайрамдал гишүүний ахлаад байгаа нөгөө стандартын ажлын хэсэг хуультай холбогдоод байгаа. Тэгэхээр энэ бусад явж байгаа нөгөө хуулийн зохицуулалттайгаа энэ бүх зүйлүүд чинь хоорондоо нийцэх ёстой гэсэн санаа байгаад байгаа юм.

Экспортод сая бас энэ Киргиз, Тажикаар бас Монгол Улсын Ерөнхийлөгчийн айлчлалтай явж байхад яг энэ Дундад Азийн орнууд Монгол малын махыг авах сонирхолтой байна. Сарлагийн мах, ямааны мах авах их сонирхолтой байна гэсэн юм илэрхийлээд байгаа. Тэгэхээр тэр болгонд нь бид нар хангалттай хэмжээнд нийлүүлэлт хийж чадах, нөгөө эрэлт нийлүүлэлт дээр Монгол Улс өрсөлдөгч болж чадах энэ салбартаа өөрсдөө ханган нийлүүлэгч болж чадах энэ стандартаа олон улсын түвшинд ч тэр үндэсний түвшинд биелүүлж чадах энэ зүйл дээр бас яг энэ агуулгыг манай гишүүд хэлээд байх шиг байна. Энэ дээр бас анхаараарай гэж үзэж байна.

Бас нэг жишээ хэлэхэд 2024 оны 6 сарын байдлаар Шинэ Зеланд 23,4 сая хоньтой, дундаж хонь 150-700 доллар, зарим тэр цэвэр үүлдрийн хар хамарт гэдэг хонь нь 1 мянган доллар хүрдэг юм байна. Манай улс 2024 онд бас 24,4 сая, бараг л 600 мянган зөрүүтэй. Хонинытой тооны тоо бол адилхан байгаад байгаа. Гэхдээ тэр ижилхэн тооны Шинэ .../минут дуусав/

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Мөнгөнцогийн Ганхүлэг 1 номерын микрофоноос.

М.Ганхүлэг: Гишүүддээ өдрийн мэндийг хүргэе. Энэхүү хуулийн төслийг гишүүдийн хамт бас бид бас өргөн мэдүүлсэн байгаа. Эхний хэлэлцүүлэг дээр ярилцаж байгаа олон асуудлууд бас байна. Энэ асуудлуудыг бас цаашдын хэлэлцүүлгүүд дээр нэлээн ярилцаад явах нь зөв юм гэсэн ийм байр суурьтай байгаагаа бас илэрхийлье. Бусад гишүүд маань орж ирээд бас саналаа өгч, энэхүү хуулийн төслийн ач холбогдлыг тал талаас нь ярилцах, дараагийн шатын бас хэлэлцүүлгүүдийг өрнүүлээсэй гэсэн ийм бодолтой байгаа юм.

Үндсэндээ Монгол Улсын эдийн засгийг солонгоруулах тухай, бусад салбаруудыг хөгжүүлэх тухай ерөнхийдөө бол бид бүхэн бас байнгын ярьж байгаа. Тэр дундаа хөдөө аж ахуйн салбар бол бид бүхний хамгийн чухал салбаруудын 1 учраас энэ салбарын бодлого үйл ажиллагааг илүү оновчтой болгох, энэ салбарт хэрэгжиж байгаа хуулиудын хэрэгжилтийг нэгдсэн байдлаар зохион байгуулахад энэхүү хуулийн хамгийн гол зорилгууд оршиж байгаа гэдгийг та бүхэндээ бас онцлон хэлье.

Мөн дээрээс нь салбарын бодлого, үйл ажиллагааг сайжруулахаас гадна тогтвортой үйлдвэрлэл, бүтээмжийг сайжруулах, өртгийн сүлжээний тодорхой энэ

шатуудад бас төрийн оролцоог зүй зохистой болгох гол агуулгууд бас энэ хууль дээр бас орсон 2 дахь үндэслэлийг та бүхэн маань онцолж хараарай.

Хөдөө аж ахуйн салбар бол газар тариалан, мал аж ахуй аль аль талаасаа бол эрсдэлийн маш өндөр эрсдэлтэй ийм бизнес гэж хэлж болно. Тэр утгаараа эрсдэлийг даван туулахад энэ салбарынхныг дэмжих чиглэлийн гол агуулгууд бас энэхүү хуулиар гол санаанууд нь бас орж ирж байгаа юм. Саяын бас гишүүдийн маань хэлж байгаа хамгийн эцсийн шатын экспортыг дэмжих чиглэлийн гол бодлогууд бас энэхүү хууль дээр санаачилга болж орж ирж байгаа юм. Ингээд төрийн дэмжлэгийг илүү оновчтой болгох, салбарын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах чиглэлээр энэхүү хуулийн гол үзэл санаа байгаа учраас тал талаас нь бас байгаа асуудлуудаа ярилцъя гэсэн ийм байр суурьтай байгаа.

Салбарын сайдын хувьд бас өөрийнхөө саналыг хэллээ. Дараа дараагийн шатын хэлэлцүүлгүүд дээр нэлээн идэвхтэй оролцоод явъя гэсэн ийм байр суурьтай байгаа. Тэгээд 1 зүйлийг би бас онцолж хэлмээр байна. Хөдөө аж ахуйн салбарт тулгамдаж байгаа олон олон асуудлуудыг бид нар, уг нь салбарын сайд өөрөө манлайлал үзүүлээд, энэ хуулийн агуулгууд дээрээ санаачилгаа гартаа аваад ажиллах бүрэн бололцоо юмнууд бол байгаа. Тэгэхээр энэ байдлаа бас цаашдаа хадгалаад ажиллаасай гэсэн ийм байр суурьтай байна. Энэ салбарын хөгжлийн төлөө олон олон бас асуудлуудыг нэг дор бас ярьж хэлэх энэ агуулга бол энэ хуулийн төслийн хэлэлцүүлгүүдийн хүрээнд бол явна. Тийм учраас гишүүдийг бас дараа дараагийн шатын хэлэлцүүлгүүдийг үүсгэж, энэхүү хуулийг хэлэлцэхийг дэмжихийг бас та бүхнээсээ хүсэж байгаа юм. Баярлалаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, хуультай холбоотой бас хэдэн саналыг хэлье гэж бодлоо. Энэ бол нэн чухал хууль. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дүнгийн дагаварт хийсэн үнэлгээний дүнгээр хэрэгжилт 40 гаруй хувьтай байгаа нь хуулийн хэрэгжилт бол маш хангалтгүй байгааг харуулж байгаа. Өнөөдөр бас асуулт асууж байгаа гишүүд, уг хэлж байгаа гишүүдийн зүгээс энэ талаар дурдаж нэлээдгүй ярилаа. Иргэдийн эрүүл мэндийн түвшин олон улсын хэмжээнд хавдраараа тэргүүлээд байгаагийн гол шалтгааны нэг үндэс нь баталгаагүй хоол хүнстэй шууд холбоотой.

Нэг талаасаа хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг 220 мянга орчим аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг энэхүү хуулиар зохицуулж байгаа боловч үүний ард бас Монгол Улсын 3,5 сая хүн амын эрүүл амьдрах, урт наслах баталгаат хоол хүнсээр хангагдах эрхийн асуудал илүү чухал гэж бас бид нар бодох ёстой. Иймээс энэ хуулийг хэлэлцэх нь бол маш чухал гэж үзэж, дэмжиж байна.

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дараах өөрчлөлтүүд бас орж байгаа. Түрүүн Мандхай гишүүн санаачлагч бас дурдлаа. Хүнсний аюулгүй байдал ба хүнсний баталгаат байдал гэсэн нэр томъёог өөрчилж нэг үгээр нэг утгатай илэрхийлэх учиртай тул нэр томъёог ойлгомжтой болгосон. Энэ олон улсын түвшинд food safety гэдэг ойлголтыг илүү өргөн хүрээтэй, чанар стандарт, баталгаат байдлыг сайжруулсан. Ингэснээр бас ялангуяа хүнсний экспортыг нэмэгдүүлэх олон улсын түвшинд бид нар гарахад нэн чухал юм.

Шошго мэдээллийн ил тод байдал, хүнсний бүтээгдэхүүний шошго тэмдэглэгээний шаардлагыг илүү тодорхой болгосон, илүү дэлгэрэнгүй мэдээлэл, гарал үүсэл, найрлага, хадгалах нөхцөл, шим тэжээлийн агууламж, заавал тусах

зохицуулалтуудыг бид нар бас оруулж өгч тусгаснаараа онцлогтой. Энэ хэрэглэгчийн мэдэх эрхийг баталгаажуулж зах зээл дээрх хоёрдмол ойлголтыг арилгах зорилготой. Гарал үүсэл, мөшгөлтийн тогтолцоо бас илүү сайжирч байгаа traceability гэдэг. Энэ бол ялангуяа Монголын хүнс экспортод гарахад нэн чухал байдаг. Үүнд мал, түүхий эд боловсруулах үйлдвэрээс эхлээд худалдаа хэрэглэгчид хүртэлх бүх үе шат бүрд нь баримтжуулдаг бүртгэл хийх шаардлагыг бид нар бас тусгасан ийм хуулийн төслийг өргөн барьсан юм байна.

Хяналтын тогтолцооны шинэчлэл, хүнсний баталгаат байдлыг хангах бие даасан агентлаг энэ бүгд нь бас тусаж чадсан нь сайн юм. Ингээд ЖДҮ-лэлд бас чиглэсэн зохицуулалтуудыг тусгасан талаар Мандхай гишүүн бас дурдлаа. Ингээд иргэдийн оролцоо мэдээлэл бол нэн чухал, хэрэглэгчийн гомдол, саналыг хүлээн авах, шийдвэрлэх бие даасан механизм бас бий болгох энэ хуулийн зохицуулалтуудыг хийж өгсөн байна гээд шинэчилсэн өөрчлөлтүүд нь өмнөх хуульд давхардалтай байсан зохицуулалтуудыг нь тодруулж, илүү ил тод, хариуцлагатай, эрсдэлийн удирдлагад суурилсан тогтолцоог бий болгох зорилготой. Ийм учраас энэ хуулийн үргэлжлүүлэн хэлэлцэх эсэх санал хураалтыг Маргааш, нөгөөдөр 5 дахь өдөр нэгдсэн чуулган байгаа.

Тэгэхээр Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу санал хураалтыг 5 дахь өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар явуулъя. 5 дахь өдөр нэгдсэн чуулгантай байгаа. Тэгээд 5 дахь өдөр үдээс хойш Улсын Их Хурлын гишүүдийн асуулгын цагтай байгаа. Тийм ээ. Тэгэхээр түүнтэй нэгтгэж, санал хураалтыг явуулъя.

12.07 цаг.

Сүүлийн асуудал дээр Байнгын хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудал дээр улс төрийн намуудын зүгээс нэмж саналуудаа өгөөд, нэгдсэн байдлаар Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах нь зүйтэй гэсэн Улсын Их Хурал дахь намын бүлгүүдээс.

Тийм учраас намын бүлгүүд Байнгын хороодод байгаа гишүүндээ бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай саналтай байвал Улсын Их Хурлын даргад албан бичгээр хандаад, өөрчлөлтүүдийг нь нэгтгээд Улсын Их Хурлын Тамгын газраас дараагийн чуулган дээр нэгдсэн байдлыг нь хангаж байгаад оруулах нь зүйтэй юм байна.

Ингээд өнөөдрийн чуулганы хэлэлцэх асуудал дууслаа. Өнөөдрийн чуулган ийнхүү өндөрлөж байна.

12.09 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ